

ДОРНОД АЙМАГ

**“ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА
“ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД” ХӨТӨЛБӨРИЙН “АВЬЯАС”, “НОМ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД МОНИТОРИНГ ХИЙХ НЬ”**

МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

2015 он
НДЭХ Дорнод салбар

МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газраас Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвших, гэр бүл, боловсрол нийгмийн орчныг бүрдүүлэх зорилго бүхий “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг 2012-2016 онд хэрэгжүүлж эхлүүлээд буй бөгөөд энэ хөтөлбөрийн хүрээнд 3 дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд: “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл”, “Авьяас”, “Ном” гэсэн хөтөлбөрүүд багтаж байна.

БШУЯамнаас Авьяас хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлж гаргасан баримт бичигтээ:

“Дэлхий ертөнц даяарчлагдан, нийгмийн харилцаанд мэдээллийн технологи, техникийн дэвшил нэвтрэх тусам хүний байгалиас заяагдмал төрөлх шинж саармагжиж, амьдралын үнэт зүйлийн тухай ойлголт өөрчлөгдөн, уламжлалт ёс суртахууны үнэ цэнэ буурч байна. Нийгмийн харилцаа, хүний сэтгэл зүйд гарч байгаа өөрчлөлтүүд нь бухимдал, ганцаардал, айдас, гэмт хэрэг, ёс суртахуунгүй явдлыг нийгэмд газар авах нөхцөл болдог бөгөөд үүний гол хохирогч нь хүүхэд юм.” гэжээ.

Манай улсад сүүлийн арван жилийн байдлаар жилд дунджаар 977 хүүхэд, 616 удаагийн гэмт хэрэг үйлдсэн бөгөөд 2011 онд шүүхээр шийтгүүлсэн 18 хүртэлх настай 1163 иргэний 124 нь 14-15 насны хүүхэд байна. Мөн нийслэлийн их, дээд ерөнхий боловсролын сургуулийн 2000 хүүхэд, залуучуудын дунд 2010-2011 онд хийсэн судалгаагаар тэдний 2.9 хувь нь бензин цавуу, 1.8 хувь нь каннабис, 0.9 хувь нь экстази хэрэглэж үзсэн гэсэн дүн гарчээ. /а

Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, өсвөр үеийнхний дунд РС тоглоомд донтох, үе тэнгийхнээ дарамтлах, гэр бүл, насанд хүрэгчид, багш сурган хүмүүжүүлэгчидтэй харилцааны зөрчилд орох, сурах дургүйн улмаас сургуулиас завсардах явдал ч буурахгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг

Иймд хүүхэд бүрийг авьяас чадварт нь тулгуурлан хөгжүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоо, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах, үндэсний хэмжээнд олон салбарын дэмжлэгтэйгээр хүүхдийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх шаардлагатай байгааг БШУЯам онцолсон байдаг. Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлд төрөөс суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих талаар заасан \. **“Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд** МУ-ын БШУСайдын 2012 оны 10 сарын 08 ны өдрийн хуралдааны А/51-р тушаалаар “Хүүхдийн авьяасыг нээж, хөгжүүлэх үйл ажиллагаа” зохион байгуулах тухай “Авьяас”, хөтөлбөр мөн А/52-р тушаалаар “Ном” хөтөлбөр батлагдан улсын хэмжээнд хэрэгжиж эхлэн үйл ажиллагаа нь явагдаж байна. Энэхүү хөтөлбөрүүд нь хөдөө орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх, цаашид хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн үйл ажиллагааг нь

сайжруулахад анхаарал хандуулах шаардлага байна гэж үзэж, энэхүү мониторингийн төслийг хэрэгжүүллээ.

НЭГ. МОНИТОРИНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Мониторингийн зорилго:

Засгийн Газраас Ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлж байгаа “Авьяас”, “Ном” хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийж улмаар гол зорилтот бүлгийн буюу хүүхдүүдийн хэрэгцээнд нийцсэн байдлаар, тэдний хөгжлийн дэмжих зорилгод хэрэгжилтийг чиглүүлэхэд нөлөөлөх

Мониторингийн зорилт:

1. “Авьяас”- Орон нутгийн сургуулиудад хэрэгжиж байгаа “Авьяас” хүрээнд орон нутагт ирж байгаа дэмжлэгийг тэгш хүртээмжтэй зөв хуваарилж байгаа эсэхийг үнэлэн судлах
2. “Ном” - хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа номнууд суралцагчдын хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх болон чанар хүртээмжийг нь судлан тодорхойлох
3. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлын талаар цуглуулсан мэдээллийг үндэслэж цаашид сайжруулах талаар зөвлөмж гарган, зохих байгууллагуудад нөлөөлөх

Мониторингийн хамрах хүрээ, хугацаа:

“Авьяас”, “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа Дорнод аймгийн төвийн болон хөдөө орон нутгийн Баянтүмэн, Чойбалсан сумын сургуулиудын багш нар, эцэг эхчүүд, сурагчид, нийгмийн ажилтнууд, БСГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан 2015 оны 01-р сарын 15-наас 06 сарын 15-ны хугацаанд гүйцэтгэлээ.

Мониторингийн арга зүй, аргачлал:

Мониторингийн ажлыг гүйцэтгэхдээ дараах аргуудыг ашиглан мэдээлэл цуглууллаа.

1) Баримт бичиг судлах арга

“Авьяас”, “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зохион байгуулах, үйл ажиллагаа хөтөлбөрийг цаашид эрчимжүүлэхтэй холбоотой холбогдох тушаал, шийдвэр, заавар зөвлөмж, хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой бичиг баримттай танилцаж судалсан.

2) Анкетын судалгааны арга

Төслийн багийн гишүүд сургуулиудын эцэг эхийн төлөөллөөс нийт 120 хүнийг түүврийн аргаар сонгон анкетын судалгаа авч боловсруулалт хийлээ.

3) Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга

Авьяс хөтөлбөрийн хүрээнд Дорнод аймгийн нийт төвийн 9 сургууль, Баянтүмэн, Чойбалсан сумын сургуулийн багш, сурагчид, эцэг эхчүүдийн дунд фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагуудыг хийж, үйл явцын тэмдэглэл хөтөлж, зарим үед бичлэг хийж баталгаажуулсан.

4) Ажиглалтын арга

Хөтөлбөрийг сургууль тус бүр өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа байдал болон дугуйлан секцийн зохион байгуулж байгаа явцад ажиглалт хийсэн.

5) Swot шинжилгээний арга

ЗГ-аас хэрэгжүүлж байгаа “Авьяс”, “ Ном” хөтөлбөрийн орон нутагт хэрэгжиж байгаа хэрэгжилтийн байдалд багш, эцэг эхчүүдийн оролцоотойгоор хамтран ярилцаж, swot шинжилгээ хийж анализ хийсэн болно.

1. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн авьяасыг нээж илрүүлэх зорилготой судалгааны ажил үр дүн багатай явагдсан. /2012 оны 10 сараас 2012 оны 11 сар/

Авьяас хөтөлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулж эхлэх үед хүүхдүүдийн авьяас, сонирхлыг тодорхойлох судалгааны ажил, цаашид үргэлжлэх хөтөлбөрийн зорилгын талаар мэдээлэл сурталчилгаа хангалтгүй хийгдсэнтэй холбоотойгоор судалгаа үр дүнгүй явагдсан, хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдож чадаагүй гэж мониторингийн үнэлгээнд хамрагдсан багш нарын дийлэнхи нь үзэж байна.

Авьяас хөтөлбөрийн судалгааны талаар эцэг эхчүүд болон хүүхдүүдэд дутуу ойлголт өгсөн мөн судалгааны зааварчилгааг бүрэн өгөөгүйгээс судалгааг үр дүн муутай болсон гэж судалгаанд оролцогчид үзэж байгаа юм.

Авьяас хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа бодит биш цаг цаас үрсэн ажил болсон. Судалгааны дагуу цаашид яаж ажиллах талаар зөвлөмж зааварчилгаа гаргаагүй багш нарт даатгаад орхисон.

Шинэ хөгжил цогцолбор сургуулийн багшийн ярианаас

Гол нь хүмүүсийн авьяасын талаар ойлголт ямар байна гэхээр авьяасыг зөвхөн дуулж бүжиглэх эсвэл спортын тал дээр авьяастай байдаг гэж ойлгож судалгаагаа бөглөсөнтэй холбоотой.

/Багш О.С-ийн ярианаас /

А авьяас гэдэг ойлголтыг тодорхойлохдоо зөвхөн спорт,урлаг гэж ойлгодог уламжлалт сэтгэлгээгээр хандсан байдал нь судалгаанд оролцогчдын ярилцлагаас харагдаж байгаа юм. Авьяас хөтөлбөрийн суурь судалгааг сургуулийн хэмжээнд нийгмийн ажилтнууд зохион байгуулан ажилласан. Маш их цаас орсон ажил болсон. Богино хугацаанд хүүхэд өөрийгөө, эцэг эх хүүхдээ, багш хүүхдийнхээ авьяасыг тодорхойлсон. Багш нар ерөнхийдөө урлаг спортод явдаг хүүхдүүдээ тодорхойлоод, авьяас нь нуугдмал байгаа хүүхдийг гаргаж ирэх асуудал ховор байсан юм. Эцэг эхчүүд хүүхдээ бүрэн тодорхойлж чадаагүй гэж боддог. Судалгааны бүрдлийг нийгмийн ажилтнууд анги тус бүрээр гарган авч сургуулийн нэгтгэл хийсэн. Энэхүү судалгаа одоо болтол анги удирдсан багш нарт хадгалагдаж байна.

/Нийгмийн ажилтануудын ярианаас/

Дугуйланд хамрагдах хүүхдийн судалгаа авсан. Судалгаа үр дүнгүй цаас бөглөөд орхисон түүнийг эргэж харж ажиллаж байгаа хүн ховор байна. Анх авсан судалгаа бодитой биш эцэг эхчүүдийн авьяасын талаарх ойлголт муу байснаас болоод хүүхэд өөрийгөө, эцэг эхчүүд хүүхдээ зөв тодорхойлж чадаагүй.

/Багш Б.М-ийн ярианаас /

Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан анхны судалгаа нь цаас барсан ямар ч үр дүнгүй богино хугацаанд багш, сурагч,эцэг эхчүүдийг бөглө гэж шаардсан тийм л судалгаа болсон шүү дээ нэгэнт хөтөлбөр хэрэгжиж байгаа юм чинь бодитой судалгаанд түшиглэж хүүхдийн сонирхол хэрэгцээнд тулгуурламаар юм.

/ Багш Д.Н-ийн ярианаас/

"Авьяас" хөтөлбөрийн багийн бүрэлдэхүүнд байдаг урлагийн нэрт зүтгэлтнүүд орон нутагт зөвлөмж, туршлагаа түгээж хүрч ажиллахгүй, зөвхөн нийслэлд үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байгаа хандлага түгээмэл байна.

"Авьяас" хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн багт нийт 33хүн буюу хөтөлбөрийн багийн ахлагч 1,нарийн бичгийн дарга1зөвлөх багийн ахлагч 1,гишүүд5,менежментийн багийн ахлагч 1гишүүд 23сургалтын багт нийт 27 хүн буюу сургалтын багийн ахлагч-1, гишүүд 26 хүн ажиллаж байгаа бөгөөд сургалтын багийн эдгээр мэргэжлийн чадварлаг хүмүүс нь нийслэл болон хөдөө орон нутгийн хүүхэд багачуудын авьяасыг хөгжүүлэхэд удирдлага арга зүй, зөвлөмж туршлагаа түгээн ажиллах ёстой гэж багш, эцэг эхчүүд үзэж байгаа боловч хөдөөгийн багш,эцэг эхчүүд, хүүхдүүд анхан шатанд нь ирж ажиллана гэдэгт их хүлээлттэй байгаа юм. Гэвч үйл ажиллагааны цар хүрээ нь нийслэлийн хэмжээнд хязгаарлагдаж, хөдөө орон нутагт хүрэхгүй байгаа талаар мониторингийн явцад дурьдагдаж байгаа юм.

Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнд манай урлагийн одод байдаг гэдэг боловч эдгээр хүмүүс нь зөвхөн хотдоо хөдөө анхан шатанд нь хөтөлбөрийг яаж хэрэгжүүлэх зөвлөмж туршлагаа түгээхгүй хүүхдийн чуулган хийсэн хэмжээнд байгаа нь учир дутагдалтай санагддаг

11-р сургуулийн дуу хөгжмийн багшийн ярианаас

Авьяас хөтөлбөрийн хүрээнд урлагийн оддын хичээллүүсэн дугуйлангийн бичлэг ,туршлагыг аймгуудад түгээн дэлгэрүүлнэ гэсэн боловч одоо болтол ирээгүй л байна. Мөн одууд өөрсдөө орон нутагт ирж туршлагаа түгээх нь зүйтэй өөрийнхөө оронд өөр хүмүүсийг явуулж байгаа нь зохистой биш юм. Манай аймагт хүүхдүүдийн биелгээ хийж өгнө гэж туршлагагүй залуу ирж байсан шүү дээ

Нийгмийн ажилтануудын ярианаас

3. "Авьяас" хөтөлбөрийг сургууль тус бүр өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа нь энэхүү хөтөлбөрийн үр өгөөжид эерэгээр нөлөөлж байгаа бөгөөд нийт хүүхдүүдийг жигд хөгжүүлэх тал дээр амжилттай байгаагийн зэрэгцээ хувь хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурлан ажиллах чиглэлээр хөгжүүлэх менежментийн үйл ажиллагаа дутмаг байна.

Хөтөлбөрийг сургууль тус бүр өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа нь ажиглагдсан. Сургууль бүр хүүхэд бүрийн авьяас чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөтэй сургуулийн үндсэн дугуйлан секцүүдээс гадна багш бүр өөрийн чаддаг мэддэг зүйлээ

сурагчдад зааж сургах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа нь энэхүү хөтөлбөрийн ойлголт,хэрэгжилт тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч байна. /Жнь: 8 дугаар сургууль 400 хүүхдийн буриад бүжиг, Хан-Уул цогцолбор сургууль 1000 хүүхдийн биелгээ,12 дугаар сургууль 80 хүүхдийн найрал дуу гэх сургуулийн онцлогийг харуулсан тоглолтыг орон нутгийн иргэдэд сурсан зүйлээрээ тайлан тавьж сайшаал хүртсэн байна. Мөн үүнээс үзэхэд авьяас хөтөлбөр нь хамт олныг оролцуулсан буюу хүүхдийн оролцоо нэмэгдүүлж массыг /нийтийг хамарсан/ хэмжээнд хүрснийг харуулж байгаа нь сайшаалтай.

Мөн үүний зэрэгцээ хөтөлбөр нь хүүхдэд өөрт нь өөрийгөө хөгжүүлэх, авьяасаа нээх боломжийг өгсөн ч хүүхэд бүр хүссэн дугуйландаа суралцах боломжгүй байгааг анхаарах шаардлагатай юм../

Багш нарын санал нэгдсэн дүгнэлтээс үзэхэд: Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр:

- Хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж бүрдсэн
- Зарим хүүхдийн авьяас илэрсэн
- Дугуйлан, секцийн төрөл нэмэгдсэн
- Дугуйланд суралцагчдын тоо нэмэгдсэн
- Эцэг эхийн оролцоо, идэвхи нэмэгдсэн гэсэн үнэлгээг ярилцлагад оролцсон

багш нар хүлээн зөвшөөрч байсан.

Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хичээлийн ээлжээс шалтгаалан танхимын хүрэлцээ муу, дугуйланд суралцах хүүхдийн тоо хязгаартай байдгаас сурагчид сонирхолтой дугуйландаа бүрэн хамрагдах боломжгүй /1-р сургуулийн багшийн ярианаас/

Кейс: Авьяас хөтөлбөр хэрэгжсэнээр олон хүүхэд хөгжсөн гэж боддог. Бүжгийн дугуйланд огт бүжиглэж чадахгүй суралцаж бүжиглэх дөртэй болж байна. Эдгээр сурагчид Жайв , Ча ча бүжиг сурсан. Манай сургуульд сэтгэхүйн дугуйлан их үр дүнтэй хичээллэсэн. Үүний үр дүнд зүүн бүсийн бага ангийн багш нарын сургалтанд бид 100 хүүхдийн ингэ ботго нийлүүлэх 9 түлхүүр рубликийн шоо эвлүүлэх үзүүлбэр үзүүлсэн. /Багш А.Д-ийн ярианаас /

4. "Авьяас" хөтөлбөрт хүүхдүүдийг хамруулахдаа багш нарын зүгээс бага ангийнхныг дугуйландаа авах сонирхол дутмаг, дунд ахлах ангийнхныг сонгож ажиллах сонирхол давамгайлж байгаа ба хүүхдийн хөгжлийн анхны түвшин, тодорхой хугацаанд гарч байгаа ахиц хөгжлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээний удирдамж байхгүй байгаа нь энэ ажлын үр дүн, өгөөжийг үнэлэхэд хүндрэлтэй болгож байна.

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд бага ангиас хамрагдах сурагчдын тоо бага байдаг мэргэжлийн багш нар том ангийн сурагчдыг сонгох сонирхолтой байдаг нь тэдний хүлээж авах чадвар нь илүүтэй холбоотой байх. Гэвч хүүхдийг хэдийчинээ багаас нь хөгжүүлж эхлэх хэрээр хүүхдийн амжилтын үзүүлэлт, үр дүн эрт мэдрэгдэж эхэлнэ. Жишээ нь Олимпийн наадамд манай тамирчдын амжилтыг ахиулья гэхэд спортоор бага ангиас нь л хичээллүүлж эхэлсэнээр амжилт, үр дүн эрт үзүүлнэ шүү дээ...

8-р сургуулийн биеийн тамирын багшийн ярианаас

Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг ямар түвшинд хүргэх ёстой тодорхой хэмжээнд шалгуур үзүүлэлт байх ёстой. Дугуйланд гарааны үнэлгээ хийж тооцдог ч хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хяналт тавьдаггүй хэдэн багш хэрэгжүүлээд л байдаг үр дүн нь яаж гарч байгаа талаар мэдээлэл ч байдаггүй. Үүнтэй холбоотойгоор хүүхэд хэрхэн хөгжиж ахиц гарч байгаад анализ хийдэггүй. Багшийн ажлыг үнэлж урамшуулах механизм ч байхгүй байгааг жаахан өөрчлөх, журам боловсруулах шаардлагатай л санагддаг.


12-р сургуулийн багшийн ярианаас

Дээрх багш нарын ярианаас үзэхэд хүүхдийн хөгжлийг үнэлэх ахиц гарч байгаа тооцох, тодорхой амжилт үр дүнд хүрэхэд, мөн багшийг урамшуулах, эцэг эхийг мэдээлэлтэй байлгах, хамтарч ажиллах, хүүхдээ тус сургуульд сургаж, дугуйлан секцэд хамруулсанаар эерэг үр дүн гарч байгаад итгэлтэй, сэтгэл хангалуун байхад туслах үнэлгээний удирдамжтай байх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа юм.

Уг нь дарааллаараа явж байгаа юм эхлээдсанхүү орохоор ярилцлагуудаас энэ асуудал гарсан болохоор болохгүй юм шиг санагдаад байна та сайн хараарай хө

5. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд нэг сургуульд олгох санхүүгийн дэмжлэг /10 сая ₮/ -н хуваарилалт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээлэл ил тод биш, сургуулиудад хэрхэн хуваарилан олгох талаарх заавар журам ойлгомжгүй хэвээр байсаар байна.

МУ-ын БШУСайдын 2012 оны 10 сарын 08 ны өдрийн хуралдаанаар “Хүүхдийн авьяасыг нээж ,хөгжүүлэх үйл ажиллагаа” зохион байгуулах тухай А/52-р тушаал батлагдсантай холбогдуулан “ Төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургуульд суралцагчийн авьяасыг хөгжүүлэхэд шаардагдах сургуулийн тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүн худалдан авах ажиллагааны зөвлөмжийн дагуу аймгийн төв, хөдөөгийн 25 сургуульд дэмжлэг / нэг сургуульд 10 сая төгрөгийн хэрэглэгдэхүүн/ олгогдсон байдлыг графикаар харуулбал:



Дээрх графикаас үзэхэд 2014 оны байдлаар нийт 8 сургуульд тус санхүүгийн дэмжлэг олгогдоод байгаа бөгөөд бусад сургуулиудын хувьд тус дэмжлэгийг дарааллын дагуу ямар нэгэн байдлаар олгогдох байх гэсэн хүлээлттэй байгаа ч ямар журмаар хэрхэн яаж олгодог талаар мэдээлэл дутмаг байгаа талаар мэдээлэл цуглуулах явцад олонтаа дурьдаж байсан болно.

Сургуулийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхэд хөгжүүлэх зардлыг тусгаж оруулах хэрэгтэй. Хөтөлбөрийн хүрээнд ирдэг хөрөнгө оруулалтыг захын сургууль гэж ялгалгүй олгодог баймаар байна
/ Багш А.М-ийн ярианаас /

Авьяас хөтөлбөрийн хүрээнд өгдөг 10 сая төгрөгийн дэмжлэгийг манай сургууль аваагүй. Ямар нөхцөл шалгуураар олгодог нь тодорхой бус, мэдээлэл бага байна. Хөтөлбөрийн хүрээнд сургууль бүрийн хэрэглэгдэхүүн, нөөц боломжийн судалгааг гаргаж түүнд нь үндэслэн санхүүгийн дэмжлэгийг олгож байх хэрэгтэй.

2-р сургуулийн багшийн ярианаас

Хөтөлбөрийн эхний жилийн санхүүжилтийг хүүхдийн тоо олон байгаа төвийн болон сумын нэг сургуулийг сонгож дэмжлэгийг олгосон. Харин дараагийн жил аль сургууль нь тодорхойгүй болсон уг нь сургуулийн судалгаанд суурилж аль болох техник тоног төхөөрөмж хөгжмийн зэмсэг дутмаг сургуульд олгомоор юм. Нэгэнт нийгмийн ажилтнууд авьяас хөтөлбөрийг сургууль дээрээ зохион байгуулж хариуцдаг учраас мэдээллийг тэнцвэртэй өгч баймаар байна. Авьяас хөтөлбөрийг эхний жил Л.Наранчимэг багш, дараа нь Б.Оюунбат мэргэжилтэн, одоо Ж.Насанжаргал мэргэжилтэн хариуцан ажиллаж байна. Ер нь хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нь солигдох нь хөтөлбөрийн үйл ажиллагаа тогтмолжихгүй өмнө нь хийсэн ажлын залгамж холбоо байхгүй байгааг анхаармаар байна. Одоо аль сургууль дэмжлэг авах нь тодорхойгүй л байна.

/ нийгмийн ажилтнуудын ярианаас /

Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад төсөв хөрөнгийн асуудал тулгамддаг. Манай сургууль хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалт ирээгүй. Бид сум орон нутгийн удирдлагуудад санал тавьсаар л байдаг юм. / Баянтүмэн сумын захирал Т.Сугаржав

Хөтөлбөрийн хүрээнд ирж байгаа санхүүгийн дэмжлэгийг манай сургууль аваагүй байна. Сургуулиудад ямар шалгуураар олгодог нь тодорхой бус байна.

Чойбалсан сумын сургуулийн багш нарын ярианаас

6. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд сургуульд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх тендерт ялсан компаниудын дэлгүүрүүд нь орон нутгаас ирж худалдан авахад зардал, чирэгдэл ихтэй, худалдан авах ажиллагааны үед тавигдах үйлчилгээний шаардлагыг хангахгүй байх тохиолдол гарч байна.

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд сургуулиудад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх компаниудыг тендерээр шалгаруулж сонгосон нь ихэвчлэн нийслэлийн компаниуд сонгогдсон байгаа бөгөөд энэ нь орон нутгийн нийлүүлэх боломжтой компаниудын оролцоог хангахгүй, төв рүү төвлөрсөн хандлагыг хэвээр хадгалсаар байгаад сэтгэл дундуур байгаагаа орон нутгийн багш, эцэг эхчүүд илэрхийлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 2014 оноос хойш худалдан авах ажиллагааны зөвлөмжийн дагуу “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд сургуульд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх дэлгүүрийн жагсаалт:

Урлагийн боловсролын	Урлагийн хувцас	Цахилгаан хөгжим	Биеийн тамирын чиглэлээр	Технологийг чиглэлээр
Монгол хуур төв 96272829	Алтай саян ХХК	Про арт 91921901	Олимпиус 99055292	Unimat education 3310588 319460
		Монгол хуур төв 96272829	Бөхийн хүчтэн клуб 99094221	
СОГК ХХК	Puba tailor ХХК 99990529	Аргусан МЮЗИК 336565	Эй ди эж	Үхэр тэрэг
Эгшиглэн магнай ХХК 99882727		Аргусан МЮЗИК 336565	Их дэвжих өргөө ХХК 99995534	
Аргусан МЮЗИК 336565	Солана ХХК 91910101	Magic solo 99056600	Их дэвжих өргөө ХХК 99995534	Lotory

Санхүүжилтийг авсан сургууль нь тоног төхөөрөмж авахдаа заавал Яамны заасан дэлгүүрүүдээс авч байгаа нь сонголтгүйгээс гадна хөдөөнийхөнд чирэгдэлтэй.

Нийгмийн ажилтнуудын ярианаас

Манай сургууль хөгжмийн зэмсэг авсан. Уг нь орон нутагтаа захиалгаар авч болно шүү дээ. 2014 оноос худалдан авах ажиллагааны тендерийн дагуу техник хэрэгслийг нийлүүлдэг болсон. Манай сургууль хөгжмийн зэмсгээ авах гээд хотод очиход тухайн дэлгүүр нь олдохгүй байсан бөгөөд “Монгол хуур” дэлгүүрийн эзнээс утасдаж, байршлыг нь асуухад СУИС-ын замын урд гэдэг. Гэтэл хүн олохооргүй, хаяггүй, байшингийн подвальд байсан нь зардал болж очиж байгаа хөдөөнийхөнд хүндрэлтэй санагдсан. Мөн биеийн тамирын хэрэгслийг Олимпиус дэлгүүр нийлүүлдэг бөгөөд тухайн дэлгүүрт байхгүй тохиолдолд нөгөө дэлгүүрт очиход тухайн дэлгүүрийн салбар нь байсан. Ер нь заавал тендерт орсон

дэлгүүр гэхээсээ илүүтэй сургуульд өөрт нь сонголтыг нь өгч болдоггүй юм уу гэж санагдсан. Мөн тус дэлгүүрүүд нь худалдан авах ажиллагааны үед гэрээгээ ч мэдэхгүй байсан зэрэг нь үнэхээр шаардлага хангахгүй санагдсан. /Гэрэлт өнгө дэлгүүр гэх мэт/
8-р сургуулийн багшийн ярианаас.

7. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд багшид олгох урамшууллын хүртээмж, тоо хэмжээ жил ирэх тусам багасч байгаа бөгөөд тус урамшуулал нь багш нарт хугацаандаа олгогддоггүй байна.

Авьяас хөтөлбөрийн хүрээнд 2012-2014 оны хичээлийн жилд дугуйлан секц удирдсан багш нарт урамшуулал олгосон талаарх тоо баримтыг нэг сургуулийн жишээн дээр авч үзэж, энэ асуудлаар багш нартай санал солилцоход жил ирэх тусам энэ тоо буурч байгаа хандлага ажиглагдаж байгаа ба багшийн урамшуулал цаг хугацаандаа олгогддоггүй талаар дурьдаж байсан.

Нэг сургуулийн жишээг дурьдвал:

Авьяас хөтөлбөр хэрэгжсэн он	Сургууль тус бүрд дугуйлан хичээллүүлсэн багш нар, цаг		
	дугуйлан хичээллүүлсэн багшийн тоо	урамшуулал авсан багшийн тоо	Нийт багшийн дугуйлан хичээллүүлсэн цаг
2012-2013 он	5 багш	5 багш	488
2013-2014 он	5 багш	3 багш	488

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүжилт нь хязгаартай тул анхан шатны байгууллага, багш нарт хүндрэлтэй байна. Авьяас хөтөлбөрийн дугуйлангийн цаг 7 хоногт 2 цаг байдаг нь хүүхдүүдийг хөгжүүлэхэд цагийн хувьд бага байдаг.

1-р сургуулийн багш нарын ярианаас

Өнгөрсөн хичээлийн жилд ажилласан дугуйлангийн урамшууллыг 12 сард олгосон. Гэхдээ чанартай сайн ажиллуулсан 2 дугуйланд өгөх чиглэл ирсэн.

Багш Б.Ц-ийн ярианаас

Найрал дуу 100 сурагч байгаа. Ганцаараа ажилладаг. Дугуйлан хичээллүүлсэн багш нарт урамшил өгөхдөө анх 5 багшаар өгч байсан өнгөрсөн онд 3 багшийн урамшуулал өгсөн.багш нарын урамшуулал багасаж байгааг анхаарах шаардлагатай.

5-р сургуулийн дуу хөгжмийн багшийн ярианаас

Дугуйлангийн урамшууллыг багш бүрт олгодог байх хэрэгтэй л дээ.

Багш Ц.Л-ийн ярианаас

8. "Ном" хөтөлбөрийн хүрээнд сургуульд ирж байгаа номнууд нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирохгүй байна.

Ном хөтөлбөрийн хүрээнд сургуульд нийлүүлэгдэж байгаа ном нь хүүхдийн анги бүлэг, нас сэтгэхүйд тохироогүй, ур чадвараас нь ахадсан, хэрэгцээ шаардлагад нийцээгүй байгаа гэдгийг багш нар ярьж байна.


№	Фокус бүлгийн ярилцлагаас
1	1 дүгээр ангийн багш нар - Ном хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа ном нь 1 дүгээр ангийн хүүхдийн нас сэтгэхүйд тохироогүй хэтэрхий олон хуудастай байна. - Хөтөлбөрийн хүрээнд ангидаа том жижиг номыг хийж байгаа ер нь 1-3-р ангийнхан биеэ дааж ном хийнэ гэдэг бол хэцүү, эцэг эхчүүд ч тусалж чаддаггүй 1 дүгээр ангийн ном нь өнгөт зурагтай түүнийгээ будаж бүтээх ажиллагаатай байх . Нийлүүлэгдэж байгаа номонд анхаарч хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг харгалзан багш нараас судалгаа авч хэрэгцээ хангасан ном нийлүүлэх нь зүйтэй
2	2 дугаар ангийн багш нар 2 дугаар ангийн ангийн сурагчид ном уншихад их цаг хугацаа шаарддаг - Хүүхдүүд өөрийн номоо зургаар илэрхийлж будах дуртай байгаа нь хүүхдүүд танин мэдэхүйн болоод өнгө будагтай номонд илүү сонирхолтой байна - Зарим номын хэмжээ их, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохироогүй номнууд байна. Иймд бага насны хүүхдэд өнгөөр будах, будаж бүтээл хийх, нас сэтгэхүйд нь тохирсон танин мэдэхүйн чиглэлийн ном байвал илүү ойлгомжтой хүртээмжтэй болох юм. - Ангийн ном хийх гэж маш их цаг хөдөлмөр зарцуулдаг мөн маш их цаас ордог гэтэл үүнийг эцэг эхчүүд ойлгодоггүй юм.
3	3 дугаар ангийн багш нарын ярилцлага - Ангийн номын сангаар олгогдсон номнуудын гадаадын зохиол бүтээл нь үг хэллэгийн хувьд шаардлага хангахгүй дурьдвал: Цагаан соёот, Пиноккио модон хүүгийн үлгэр гэх мэт номнуудыг хүүхэд сонирхдоггүй . Харин Бэмби ба ойн амьтад гэх мэт үлгэрийн зурагтай номнуудыг амтархан уншиж байна .Бага ангийн сурагчид хэт зузаан ном уншиж чадахгүй , гадаад үгтэй өгүүллэг бүтэн уранзохиолын роман ч байна. Энэ нь тэдний сэтгэхүйн онцлогт тохирохгүй байна. - Хүүхэд богино хэмжээний ,зурагтай ном сонирхож уншихаас гадна монгол

	ардын үлгэрийг унших дуртай түүгээрээ дүр бүтээж тоглох нь тэдний хувьд бахархал байдаг нь харагддаг.
4	4 дүгээр ангийн багш нар - Номын сангаар нийлүүлэгдэж байгаа ном нь хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогт тохироогүй ахадсан номнууд ирж байна. - Ном хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүүхэд ном унших дуртай ярих чадвар нь хөгжиж байна. Мөн ой тогтоолт, хэл ярианы чадвар нь илүү сайжирч байгаа сайн тал байгаа - Бага ангийн хүүхэд ер нь том номонд сонирхолгүй нимгэн зурагтай танин мэдэхүйн номонд мөн оньсон техникийн ном их сонирхон унших дуртай байдаг.
5	5 дугаар ангийн багш нарын ярилцлагаас - Сургуулийн номын сангаар дамжин ирж байгаа ангийн номын санд ирж байгаа ном нь нас сэтгэхүйн онцлогт тохироогүй номнууд байдаг. Үүнээс дурьдахад Монголын сэтгэхүйг ариусгахуй,ногоон дарь эх,Цагаан дарь эх,Жангар гэх мэт зарим номнууд уншихад хүнддэж байна. - Хүүхдэд бага хэмжээний сонирхол татахуйц жижиг жижиг өгүүллэгүүд байвал зохимжтой. Ангийн номын сангийн ном нь хэллэг хүнд дээшээ ангиудад үзэх номнууд ирж байгаа ба 2дугаар ангийн тайлбар толийг гэхэд 5дугаар ангид үзэх жишээтэй байгаа юм. - Жангар туужийг өнөөдөр гэхэд 11-12дугаар ангид үзэж байгаа шүү дээ. Тиймээс хүүхдэд ойлгомжтой үг хэллэг яруу тод, бага хэмжээний танин мэдэхүйн,сэтгэхүй хөгжүүлэх номнуудыг түлхүү байвал үр дүнгээ өгч чадна - Бага ангид уншихын хичээл хасагдсан нь харамсалтай байдаг юм хүүхэд уншиж байж л ой тогтоолт сайжирдаг уг нь уншихын дээр уншлагаа хийж байвал илүү үр дүнтэй юм


9. "Ном" хөтөлбөрийн талаарх эцэг эхчүүдийн мэдээлэл боломжийн түвшинд байгаа бөгөөд тэдний зүгээс тус хөтөлбөрийн үр дүнд хүүхдүүдийн сурах чадвар сайжрахад эерэгээр нөлөөлж байна гэж үзэж байна.

Ном хөтөлбөрийн хүрээнд ямар ахиц өөрчлөлт гарсан талаар анкетын асуулга авч үзэхэд эцэг эхчүүд дараах байдлаар хариулсан байна.

1. **Та ном хөтөлбөрийн талаар хэр мэдэх вэ?** гэсэн асуултад 8%-аас бусад нь ямар нэгэн байдлаар мэднэ гэж хариулжээ.



2. **Та хүүхэддээ сүүлийн нэг жилд сурах бичгээс өөр шинэ ном худалдан авч өгсөн үү?** гэсэн асуултад 75% нь ном худалдаж авч өгдөг болсон гэж хариулсан байгаа нь эцэг эхчүүдийн хандлагад ч нөлөөлсөн гэж үзэж болох юм.



Хүүхэддээ ном худалдаж авч өгөөгүй шалтгаан нь

- Номын дэлгүүр хомс
- Хүүхдэд тохирсон ном байдаггүй
- Амьдралын боломж тааруу
- Ном худалдаанд үнэтэй байдаг
- Сурагчдын насны онцлогт тохирсон ном ховор

3. **Ном хөтөлбөр хэрэгжсэнээр танай хүүхдэд ямар ахиц өөрчлөлт гарсан бэ?** гэсэн асуултын хариултад дараах байдлаар хариулсан нь тус хөтөлбөрийн үр дүнг тодорхой түвшинд үнэлж байна гэж үзэж болохоор байна.

Эцэг эхчүүдийн хариулт:

- Ном унших дуртай болсон
- Сэтгэж бодох чадвар сайжирсан
- Сурлагын түвшин нь ахисан, Шүлэг цээжлэсэн
- Ойлгосноо ярих чадвартай болсон
- Бие даан аливааг хийх чадвартай болсон
- Номноос мэдээлэл мэдлэг авч болохыг ойлгосон
- Номын тэмдэглэл хийж сурсан
- Уншсанаа ярьж чаддаг болсон
- Үлгэр болон танин мэдэхүйн номыг сонирхож уншдаг болсон


4. **Танай хүүхдийн анги номын сантай юу?** гэсэн асуултад 100% тийм гэж хариулжээ.

10. "Ном" хөтөлбөрийн хүрээнд нэг хүүхдэд ноогдох номын хүртээмж тааруу байгаа зарим сургуулиудад өмнө нь хүүхдийн ном уншихад дэмжлэг болох, номын хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хэрэгжсэн төслүүдийн материаллаг баазад түшиглэн уг хөтөлбөр хэрэгжиж байна.


Ном хөтөлбөрийн хүрээнд 2012-2013 оны хичээлийн жилийн 1-5р ангийн номын сангийн номын төрөл, тоо

Нэг сургуулийн нэг бүлгийг төлөөлөн үзүүлвэл::

Анги	1	2	3	4	5
Төрөл	18	22	25	32	36
	35	44	46	62	76



Номын төрөл тоо олон нийлүүлэгдэж байгаа харагдаж байгаа ч нэг ангийн 35 сурагчтай ангид 1 төрлийн 2 ширхэг ном оногдож байна .



ГУРАВ. ДҮГНЭЛТ

Дүгнэлт 1. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн авьяасыг тодорхойлох судалгааны ажил нь хөтөлбөрийн зорилгын талаар мэдээлэл сурталчилгаа дутуу хийгдсэнээс үр дүн багатай явагдсан.

Дүгнэлт 2. Авьяас" хөтөлбөрийн багийн бүрэлдэхүүнд байдаг урлагийн "Одод" хөдөө орон нутагт туршлагаа түгээж хүрч ажиллахгүй, зөвхөн нийслэлд үйл ажиллагаа нь төвлөрч байна.

Дүгнэлт 3 "Авьяас" хөтөлбөрийг Хөтөлбөрийг сургууль тус бүр өөр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлж байгаа нь энэхүү хөтөлбөрийн үр өгөөжид эерэгээр нөлөөлж байгаа бөгөөд нийт хүүхдүүдийг жигд хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаагийн зэрэгцээ хувь хүүхдийн хэрэгцээ сонирхлын чиглэлээр хөгжүүлэх менежментийн үйл ажиллагаа дутмаг байна

Дүгнэлт 4 "Авьяас" хөтөлбөрт хүүхдүүдийг хамруулахдаа багш нарын зүгээс бага ангийнхныг дугуйландаа авах сонирхол дутмаг, дунд ахлах ангийнхныг сонгож ажиллах сонирхол давамгайлж байгаа ба хүүхдийн хөгжлийн анхны түвшин, тодорхой хугацаанд гарч байгаа ахиц хөгжлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, үнэлгээний удирдамж байхгүй зөвхөн хичнээн хүүхэд,хэдэн дугуйланд суралцсанаар хязгаарлаж байгаа нь энэ ажлын үр дүн, өгөөжийг үнэлэхэд хүндрэлтэй болгож байна

Дүгнэлт 5. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд нэг сургуульд олгох санхүүгийн дэмжлэг /10 сая ₮/ -н хуваарилалт, зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээлэл ил тод биш, сургуулиудад хэрхэн хуваарилан олгох талаарх заавар журам байгаа ч аль сургуульд ямар шалгуураар олгох нь тодорхойгүй хэвээр байсаар байна.

Дүгнэлт 6. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд сургуульд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэх тендерт ялсан компаниудын дэлгүүрүүд нь орон нутгаас ирж худалдан авахад зардал, чирэгдэл ихтэй, худалдан авах ажиллагааны үед тавигдах үйлчилгээний шаардлагыг хангахгүй байх тохиолдол гарч байна.

Дүгнэлт 7. "Авьяас" хөтөлбөрийн хүрээнд багшид олгох урамшууллын хүртээмж, тоо хэмжээ жил ирэх тусам багасч байгаа бөгөөд тус урамшуулал нь багш нарт хугацаандаа олгогддоггүй байна.

Дүгнэлт 8. "Ном" хөтөлбөрийн хүрээнд сургуульд ирж байгаа номнууд нь хүүхдийн хэрэгцээ шаардлага, нас сэтгэхүйн онцлогт тохирохгүй байна.

Дүгнэлт 9. "Ном" хөтөлбөрийн талаарх эцэг эхчүүдийн мэдээлэл боломжийн түвшинд байгаа бөгөөд тэдний зүгээс тус хөтөлбөрийн үр дүнд хүүхдүүдийн сурах чадвар сайжрахад эерэгээр нөлөөлж байна гэж үзэж байна.

Дүгнэлт 10. "Ном"хөтөлбөрийн хүрээнд нэг хүүхдэд ноогдох номын хүртээмж тааруу байгаа зарим сургуулиудад өмнө нь хүүхдийн ном уншихад дэмжлэг болох,номын хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хэрэгжсэн төслүүдийн материаллаг баазад түшиглэн уг хөтөлбөр хэрэгжиж байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Дээрх мониторингийн дүгнэлтэнд үндэслэсэн зөвлөмж:

Боловсрол, Соёл Шинжлэх ухааны яаманд:

- Удирдах шатны дээд байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ өгч, заавар зөвлөмж гарган эцэг эх , олон нийтийн оролцоог хангаж ажиллах

- Авьяас хөтөлбөрийн хүрээнд үндэсний багийн гишүүн нэрт 29 одыг хөдөө орон нутагт анхан шатанд нь ажиллуулах буюу зөвлөмж туршлагыг нь түгээлгэх
- Цаашид хөтөлбөрийн хүрээнд өгч байгаа дэмжлэгийн сургуулийн тоог нэмэгдүүлэх
- Тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг сургуульд өөрт нь сонголтыг нь олгодог байх
- Багш нарын урамшууллыг хугацаанд нь олгодог болох
- БШУЯамнаас хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа ном нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байхад анхаарах
- Номын хүртээмжийг сайжруулахад анхаарах
- Бага ангийг ном унших хичээлийн цагтай болгох

Хөтөлбөрийн хүрээнд техник хэрэгсэл нийлүүлэх байгууллагуудад:

байгууллагуудад:

- Техник хэрэгслийн талаар тухайн орон нутагт нь зах зээлийн судалгаа хийж хэрэгцээ шаардлагыг тодорхойлон с захиалга авах, хүргэж өгөх үйлчилгээ үзүүлэх, хямд үнийн бодлого барьж ажилладаг болох
- Номыг зөвхөн тоогоор нийлүүлэх биш чанарт анхаарч нийлүүлдэг байх
- Бага ангийнханд танин мэдэхүйн өнгө будагтай бага багаар уншаад урамшихаар цөөхөн хуудастай, номыг нийлүүлдэг байх
- Дунд ахлах ангийнхны хэрэгцээ шаардлагад нийцсэн номыг бүтээгчидтэй хамтран ажиллах

Дорнод аймгийн Боловсрол Соёлын газарт:

- “Авьяас” хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар сургууль тус бүрт судалгаанд үндэслэн, үнэлэлт дүгнэлт өгч үйл ажиллагааг нь эрчимжүүлэх /эхний жил сүр дуулиантай болоод л өнгөрдөг хэвшмэл байдлаас гарах/
- Хөтөлбөрийн хүрээнд өгдөг дэмжлэгийг ямар шалгуураар аль сургуульд өгч байгаа тухайгаа сургуулиудад ил тод мэдээлдэг байх
- Хөтөлбөрийг хариуцсан мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах

Сургуулийн удирдлагуудад:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийг томилж орхих бус харин багш нарын оролцоог хангахад нь дэмжиж, хяналт тавин ажиллахаас гадна хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарынхаа дуу хоолойг сонсож тэдний санал бодлыг хэрэгжүүлэн ажиллах
- Сургууль хөтөлбөрийнхөө хэрэгжилтэнд оролцооны аргыг ашиглан үнэлгээ өгч, заавар зөвлөмж гарган эцэг эх, олон нийтийн оролцоог хангаж ажиллах
- Номын санч болон эцэг эхчүүд нь багштай хамтран ном унших хөдөлгөөн тогтмол өрнүүлж багшийн ажлын ачааллыг багасгах ажлыг зохион байгуулах

Нийгмийн ажилтнуудад:

- Хөтөлбөрийн хүрээнд анги удирдсан багш, дугуйлан, секц хариуцсан багш нартай хамтран ажиллах
- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд сурагчдаас болон эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авч түүний мөрөөр ажиллах
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар эцэг эх олон нийтэд мэдээллийн хэрэгслээр сурталчлах

Дугуйлан удирдсан багш нарт:

- Тухайн хүүхдийн эцэг эхэд хичээлийн жилийн эхнээс шалгуур үзүүлэлтийг нь гарган өгч хичээлийн жилийн эцэст сурсан мэдсэн зүйлийг нь хамтран тодорхойлж ахиц амжилтыг нь эцэг эхчүүдэд сурталчилж , тэднийг идэвхижүүлэх
- Багш нар гарын дор материал ашиглан жижиг хөгжмийн зэмсгүүдийг хийж ашиглах

Эцэг эхчүүдэд:

- Дугуйлан секцийн хичээлийн явцад тухайн багш нартай хамтран ажиллаж хүүхдээ дэмжих, урамшуулах сэтгэлгээнд суралцах
- Хөтөлбөрийн хэрэгжилттэнд эцэг эхийн зөвлөл, хороо нь хөндлөнгийн үнэлгээ хийж хамтран ажиллах

ХАВСРАЛТ

Авьяас хөтөлбөр: Swot шинжилгээ

Хөтөлбөрийн давуу тал нь	Хөтөлбөрийн сул тал нь	Хөтөлбөрийг сайжруулахад юуг анхаарах
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж бүрдсэн - Зарим хүүхдийн авъяас илэрч гардаг. - Эцэг эхчүүд хүүхдээ дугуйлан секцд хамруулах дуртай болсон - Олон төрлийн секц дугуйлан хичээллэж байна. - Хүүхэд эцэг эхийн оролцоо нэмэгдсэн	- Хөтөлбөрийн хүрээнд ирж байгаа санхүүгийн дэмжлэг нь 2012-2016 он хүртэл тоног төхөөрөмжөөр хангана гэсэн боловч цөөн тооны сургуульд өгөөд байна. Жилдээ 3-4 сургуульд өгөх хэрэгтэй - Санхүүжилтийг авсан сургууль нь тоног төхөөрөмж авахдаа авахдаа заавал Яамны заасан дэлгүүрүүдээс авч байгаа нь сонголтгүйгээс гадна хөдөөнийхөнд чирэгдэлтэй - Сургалтын тоног төхөөрөмж муу сургуулиуд эдийн засгийн боломж муу - Эцэг эх нь дэмждэггүй хөгжүүлсэн авъяасыг нь чамладаг том зүйл шаарддаг. - Авъяасын судалгаа бодит биш цаг цаас үрсэн ажил болсон - Авъяасын судалгааны дагуу цаашид яаж ажиллах талаар зөвлөмж зааварчилгаа гаргаагүй багш нарт даатгаад орхисон - Үнэлгээ байхгүй - Үр дүнг тооцоход цаг хугацаа их шаардаж байна. - Дугуйлан удирдсан багш нарын урамшууллыг цагт нь олгодоггүй	- Хөтөлбөрийн хүрээнд өгч байгаа дэмжлэгийг жилдээ 4-5 сургуульд олгодог байх - Тоног төхөөрөмж авахад заавал тусгай дэлгүүр заахгүй сургуульд өөрт нь сонголтыг өгдөг байх - Хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг өгөхдөө ямар шалгуураар өгч байгаа тухайгаа сургуулиудад ил тод мэдээлдэг байх - Авъяас хөтөлбөрийн багийн гишүүд гээд нэрт зүтгэлтнүүд байдаг тэр хүмүүс хөдөө орон нутагт анхан шатанд нь сургуулиудад ажиллаж зөвлөмж туршлагаа түгээвэл үр дүнтэй болно - Багш нарын урамшууллыг хугацаанд нь олгдог байх - Хөтөлбөрийг эрчимжүүлэх шаардлагатай эхний жил сүр дуулиантай болоод л өнгөрдөг хэвшмэл ойлголтоос гарах

Нөөц боломж : - Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх - Багш нар гарын дор материал ашиглан жижиг хөгжмийн зэмсгүүдийг хийж ашиглаж болно	Эрсдэл : Дугуйлан хичээллэх байр танхим хүрэлцэхгүй учраас оройн цагаар хичээллэхэд эрсдлүүд гарч болно.
---	---

Ном хөтөлбөр: Swot шинжилгээ

Хөтөлбөрийн давуу тал нь	Хөтөлбөрийн сул тал нь	Хөтөлбөрийг сайжруулахад юуг анхаарах
- Бага ангиуд ангийн номын сантай болсон. - Хүүхэд бүр карттай ном уншаад тэмдэглэл хөтлөх аргачлалтай болсон. - Том жижиг ном хийж сурсан. - Бага ангийн сурагчид номын багц аялуулдаг багш нар эцэг эхтэй хамтарч ажилладаг - Уншсан зохиолоор жүжигчилсэн тоглолт сурсан	- Бага ангид том жижиг ном хийхэд маш их цаас зардал ордог 1дүгээр анги уншиж чадахгүй учраас тусгайлан цаг гаргаж уншиж өгдөг багш нарын ачаалал их - Бага ангийн сурагчдад үг хэллэг, сэтгэхүйд ахадсан номнууд нийлүүлэгдэж байна. - Дунд ахлах ангид унших ном байхгүй хүртээмж муу. - Хөтөлбөрийг зөвхөн бага ангийн багш, монгол хэлний багш номын санч хамтран хэрэгжүүлдэг. - Анги удирдсан багш нар дунд ахлах ангиуд ач холбогдол өгдөггүй. - Хөтөлбөрийг зөвхөн Монгол хэлн уран зохиолын багшийн ажил мэт ойлгож хэрэгжүүлж байна. - Хөтөлбөр нь зөвхөн бага ангийн багшид зориулагдсан мэт ойлголттой байдаг аль ч сургууль	- Хөтөлбөрийн хүрээнд ирж байгаа ном нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх - Бага ангийнханд танин мэдэхүйн өнгө будагтай цөөхөн хуудастай номыг нийлүүлдэг байх - Хөтөлбөрийг та нар хэрэгжүүлэх нь үүрэг мэт хандлагаар биш хэрэгжилтэнд үнэлгээ өгдөг байх, заавар зөвлөмж гаргадаг байх - Багш нарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж үнэлж дүгнэдэг болгох - Номыг зөвхөн тоогоор нийлүүлэх биш чанартай үр өгөөжтэй номнуудыг нийлүүлдэг байх - Номын хүртээмжийг сайжруулах дунд ахлах ангид яамнаас “ ангийн номын “ сантай болгох хэрэгтэй.

Нөөц боломж :

- Гэртээ хэрэглэхгүй байгаа номоо авчрах бусадтайгаа хуваалцах.
- Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- ахлах дунд ангийн сурагчдын сонирхол хэрэгцээнд тулгуурласан номыг нийлүүлэх

Эрсдэл :

- Зарим номын хэмжээ их хүүхдийн насны онцлогт тохироогүйгээс ачаалал даахгүй байх
- сэтгэхүйн онцлогт тохироогүйгээс буруу үлгэр дууриалал авах

Мониторингийн төслийн хүрээнд Дорнод аймгийн төвийн нийт 9 сургууль,хөдөө Баянтүмэн,Чойбалсан сумын сургуулийн багш нарын дунд хийсэн фокус болон ганцаарчилсан ярилцлагад нийт давхацсан тоогоор 30удаагийн ярилцлагад 200гаруй багш нар, түүвэрлэж төлөөлсөн эцэг эхчүүдийн төлөөлөл 30,сурагчдын төлөөлөл 30 /дотуур байрны сурагчид / судалгаанд 120 эцэг эхчүүд хамрагдлаа

Ярилцлагууд тэмдэглэл:

Хэрлэн сумын 2-р сургуулийн багш нар

- Багш Ж.Ганчимэг: Бага ангийн сурагч дугуйланд хамрагдаж чадахгүй байна. Ялангуяа 1-р ангийн сурагчид. Дугуйлангийн багш нар ахлах, дунд ангийнхантай л ажиллаж байна.
- А.Дэлгэрмаа: Авьяас хөтөлбөр хэрэгжсэнээр олон хүүхэд хөгжсөн гэж боддог. Бүжгийн дугуйланд огт бүжиглэж чадахгүй суралцаж бүжиглэх дөртэй болж байна. Эдгээр сурагчид Жайв, Ча ча бүжиг сурсан. Манай сургуульд сэтгэхүйн дугуйлан их үр дүнтэй хичээллэсэн. Үүний үр дүнд зүүн бүсийн бага ангийн багш нарын сургалтанд бид 100 хүүхдийн ингэ ботго нийлүүлэх, 9 түлхүүр, рубликийн шоо эвлүүлэх үзүүлбэр үзүүлсэн.
- Д.Дайрийжав: Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд АУБ нарын оролцоо чухал юм. Авьяас хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг урлагийн үзлэгт байнга ордог хүүхдийг биш өөр хүүхдийг хөгжүүлснээр гарах ёстой гэж боддог. .
- Ж.Ганчимэг: Дугуйланд хүүхэд орох гэхээр чадваргүй гээд зарим багш нар хассан.
- Б.Мөнгөнтуул: Манай ангийн сурагчид 100% дугуйлангуудад хамрагддаг. Хэр хөгжиж байгаа талаар ойлголтгүй байна.
- Б.Энхнайрамдал: Анх авьяасыг тодорхойлох судалгааг сайн судалгаа болсон гэж үзэхгүй байна. Хугацаа их бага байсан. Эцэг эхчүүд хүүхдээ их мундаг үнэлж байсан. Яг эцэг эхчүүдийн хүүхдээ тодорхойлсон авьяасыг нь шалгахгаар худлаа байдаг.
- А.Адьяаням: Дугуйланд хамрагдах хүүхдийн судалгаа авсан. Судалгаа үр дүнгүй цаас бөглөөд орхисон түүнийг эргэж харж ажиллаж байгаа хүн ховор байна.
- А.Дэлгэрмаа: 4,5-р ангиас хүүхдийн авьяас тодорч эхэлдэг. Миний хүүхэд их авьяастай гээд хүүхдээ худлаа үнэлдэг. Манай сургууль урлаг, спортын заалгүй учраас аливаа дугуйлан явуулахад анги танхимын асуудал их хүнд байдаг.
- Б.Энхнайрамдал: Хүүхдийн тоо дугуйлан бүрт харилцан адилгүй байна. Хэрэглэгдэхүүн дутмаг. Шатрын дугуйлан ажиллуулахад багшид нийтэд нь зааж өгөхөөр ханын шатар зайлшгүй хэрэгтэй болдог.
- Н.Батзориг: Материаллаг орчин, байр шаардлагатай байна.
- Б.Цэрмаа: Зарим сурагч хэт олон дугуйланд хамрагдаж байгааг АУБ нар сайн нарийн бүртгэж хүүхдүүдэдээ зөвлөгөө өгөх хэрэгтэй. Үлдсэн сурагчдаа хэрхэн хөгжүүлэх тал дээр АУБ нар, эцэг эхчүүдтэй ярилцах хэрэгтэй
- Д.Дайрийжав: Хүүхдийг өөрийнх нь сонирхсон зүйлээр хөгжүүлэх хэрэгтэй. Энэ хүүхэд дуулдаг учир чи миний дугуйланд яв гэж тулгахгүй байх ёстой.
- Б.Цэрмаа: Өнгөрсөн хичээлийн жилд ажилласан дугуйлангийн урамшууллыг 12 сард олгосон. Гэхдээ чанартай сайн ажиллуулсан 2 дугуйланд өгөх чиглэл ирсэн. Авьяас хөтөлбөрийн мөн чанарыг алдагдуулаад байна. Зөвхөн 5 дугуйлангаар биш ангидаа сайхан бичих, хурдан унших, алдаагүй зөв бичдэг болох, дэлхийн атлас дээр улс орныг зөв заадаг болох гээд олон чиглэлээр ажлыг хийж болно. Авьяас гэхээр урлаг спортоор төсөөлөөд байх шиг байна.
- Багш Доохүү: “ Авьяас” хөтөлбөрийн хувьд дугуйланд хамрагдах сурагчдын тоо бага, багшийн хүрэлцээ муу байгаа. Багш нар өөрсдөө анги ангидаа чаддаг чаддагаараа дугуйлан хичээлүүлж байна. “ Авьяас “хөтөлбөр анх хэрэгжиж эхлэхэд авсан судалгаа бодитой биш эцэг эхчүүдийн авьяасын талаарх ойлголт муу байснаас болоод хүүхэд эцэг эхчүүдийн судалгаа хоорондоо их зөрүүтэй байх жишээтэй. Гол нь хүмүүсийн авьяасын талаар ойлголт ямар байна гэхээр авьяасыг зөвхөн дуулж бүжиглэх, эсвэл спортын тал дээр авьяастай байдаг гэж ойлгож судалгаагаа бөглөсөнтэй холбоотой
- Багш Баярхүү: Авьяас хөтөлбөрийн хүрээнд өгдөг 10 сая төгрөгийн дэмжлэгийг манай сургууль аваагүй. Ямар нөхцөл шалгуураар олгодог нь тодорхой бус, мэдээлэл бага байна. Хөтөлбөрийн хүрээнд сургууль бүрийн хэрэглэгдэхүүн, нөөц боломжийн судалгааг гаргаж түүнд нь үндэслэн санхүүгийн дэмжлэгийг олгож байх хэрэгтэй.

Улсын тэргүүний лаборатори Хан-Уул цогцолбор сургуулийн багш нар

- Нийгмийн ажилтан Э.Булгамаа: Сургууль дээр бага боловсролын хүрээнд “Авьяас” хөтөлбөрөө би хариуцдаг.Хөтөлбөрийн хүрээнд шатар, 3 төрлийн хөгжим, бүжгийн дугуйлан хичээллэдэг.бага ангийн сурагчдын дунд дугуйлан цөөн байдаг. Манай сургууль хөтөлбөрийн хүрээнд ирж байгаа хөрөнгө оруулалт аваагүй уг нь тодорхой шалгуураар өгөх ёстой байх. Багш нар ч урамшууллаа өнгөрсөн хичээлийн жилд 3 хүнээр олгосон. Уг нь 5 багшид олгож байсан юм. Хөтөлбөрөө анхан шатандаа яаж хэрэгжиж байгааг хэмжих хэмжүүр байдаггүй сургууль тус бүр өөр өөрсдөө ажил явуулаад л байдаг. Үр дүн нь бусад сургуулиудаас ямар байгааг олж харах боломж байдаггүй юм.
- Хөгжмийн багш Д.Оюунчимэг: Багш нар хүүхэд бүрээ ямар нэг дугуйланд хамруулах хүсэлтэй байдаг. Гэтэл үндэсний хөгжмийн дугайланд хүүхдийн нас биеийн онцлогийг харгалзаж үзэх шаардлагатай учраас 4-5 дугаар ангийхан л хамрагдах боломжтой байдаг. Хүүхдийг дугуйлангаар дамжуулж хөгжүүлэх хэрэгцээ шаардлага их байдаг.
- Хөгжмийн багш Г.Одонзул: Хүүхдийг ямар нэг дугуйланд хамруулахдаа насны онцлогийг харгалзаж өөрт нь тохирсон зүйлд нь хамруулах хэрэгтэй.
- Хөгжмийн багш Д.Оюунчимэг: ЕБС-д хөгжмийн багш нар уртын дууг заавал заах шаардлагатай байдаг. Гэтэл уртын дуугаа мэдэхгүй учраас заахад бэрхшээлтэй байна. Энэ чиглэлийн сургалтуудыг сайн зохион байгуулах хэрэгтэй байна. Мөн “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд авсан судалгаа бодитой биш байсан. “Авьяас” гэдгээ өргөн хүрээнд ойлгохгүй спорт, урлагийн хүрээнд л баригдчихдаг. Хүүхдийн өөр бусад авьяасыг хөгжүүлэх, нээх талаар эрэл хайгуул хийх хэрэгтэй.

Улсын тэргүүний 5 дугаар сургуулийн багш нар

- Багш Г.Ганбаяр: 45 сурагчтай 2 ээлжээр хичээллэдэг. Зургийн хэрэгсэл дутмаг. Авах гэхээр 150000 – 300000 төгрөг шаардлагатай болдог. Авьяастай боловч амьдралын боломжгүй сурагчид их байна .
- П.Мөнхбат: Ширээний теннисний дугуйлан 3 жил хичээллэж байна. Хүүхдийн амжилт ч нилээн ахиж байгаа. Багаараа 1-д орсон. Улсад явах эрх авсан. Анхан шатнаас орсон 2 сурагч улсад тэмцээнд оролцож байгаа. Цаашид бид хүүхдийг ямар түвшинд хүргэх ёстой вэ? Хүүхдийг үнэлэх аргачлал байхгүй. Хичээллэж буй цаг бага байна. 1 сайн цохиур авахад 450000 төг байдаг юм.
- Ц.Эрдэнэцэцэг: Спорт бүжгээр 150 хүүхэд хичээллэж байна. Урлаг зааланд модон шалан дээр бүжиглэдэг. Хувцас нь амархан элэгдэж урагддаг. Бүжгийн толь, бүжгийн бэлтгэлийн тулгуур мод шаардлагатай байгаа. Бүжгийн хувцас бага анги – 80.000-100.000 төг, дунд анги 150.000 – 160.000 төг болдог. Үүнийг эцэг эхээс нь гаргуулдаг. Дугуйлангийн цаг бага байна.
- Б.Бямбацогт: Найрал дуу 100 сурагч байгаа. Ганцаараа ажилладаг. Дугуйлан хичээллүүлсэн багш нарт урамшил өгөхдөө анх 5 багшаар өгч байсан өнгөрсөн онд 3 багшийн урамшуулал өгсөн.багш нарын урамшуулал багасаж байгааг анхаарах шаардлагатай
- Б.Ариунзаяа: Авьяас хөтөлбөрийн хүрээнд зарим нэг дугуйланг баг дээр ардын авьяастнаар хичээллүүлвэл эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдэж болох юм.

Аймгийн тэргүүний 8 дугаар сургуулийн багш нар

- Дуу хөгжмийн багш Р.Батболд: Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнд манай урлагийн одод байдаг боловч эдгээр хүмүүс нь зөвхөн хотдоо хөдөө анхан шатанд нь хөтөлбөрийг яаж хэрэгжүүлэх зөвлөмж туршлагаа түгээхгүй хүүхдийн чуулган хийсэн хэмжээнд байгаа нь учир дутагдалтай мэт санагддаг мөн хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг ямар түвшинд хүргэх ёстой тодорхой хэмжээнд заалт шалгуур үзүүлэлт байх ёстой .Гэтэл ямар ч хэмжүүр байхгүй байна. Дугуйланд гарааны үнэлгээ хийж тооцох системтэй байдаггүй хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар хяналт тавьдаггүй энэ нь хөтөлбөр хэдэн багш сургууль дээрээ хэрэгжүүлээд л байдаг үр дүн нь яаж гарах талаар мэдээлэл ч байдаггүй юм.
- Ө.Ганзул: авьяас хөтөлбөр хэрэгжиж байгаа нь сайшаалтай боловч дугуйлангийн тоо цөөн байна. Урамшууллаа ч хугацаандаа өгч чаддаггүй .Манай сургууль хөгжмийн зэмсэг авсан гэвч Яамнаас нь УБ хотын тэр дэлгүүрээс ав гээд заагаад байх юм. Уг нь орон нутагтаа захиалгаар авч болно шүү дээ хөдөөнийхөн хөгжмөө авах гээд хот явах нь үргүй зардал баймаар юм.
- 8дугаар сургуулийн багш нар: манай сургууль хөгжмийн зэмсгээ авах гээд хотод очиход тухайн дэлгүүр нь олдохгүй Жнь: “Монгол хуур” дэлгүүрийн эзнээс олон удаа утасдаж байж байршлыг нь асуухад СУИС-ын замын урд гэдэг гэтэл хүн олохооргүй хаяг байхгүй байшингийн подвальд байдаг юм байналэй .Бидэнд удаа дараа төвөг удаж байсан нь зардал

болж очиж байгаа хөдөөнийхөнд хүндрэлтэй байсан. Мөн биеийн тамирын багш хэрэгслээ үзэхээ очиход ганц олимпиус нэртэй мөртлөө түүнээс салбарласан 2-3 дэлгүүр байсан гэсэн. Ер нь заавал тендерт орсон дэлгүүр гэхээсээ илүүтэй сургуульд өөрт нь сонголтыг нь өгч болдоггүй юм уу гэж санагдсан Яагаад гэвэл тодорхой дэлгүүр заадаг тэдгээр дэлгүүрүүд нь худалдан авах гэрээ канрактаа ч мэддэггүй юм байна лэй Жнь:/ Гэрэлт өнгө дэлгүүр /

- Д.Намсрай: хөтөлбөрийн хүрээнд авсан анхны судалгаа нь цаас барсан ямар ч үр дүнгүй богино хугацаанд багш,сурагч,эцэг эхчүүдийг бөглө гэж шахсан тийм л судалгаа болсон шүү дээ нэгэнт хөтөлбөр хэрэгжиж байгаа юм чинь бодитой судалгаанд түшиглэж хүүхдийн сонирхол хэрэгцээг тодорхойлмоор байгаа юм.

Аймгийн тэргүүний 11дүгээр сургуулийн багш нар

- Нийгмийн ажилтан Туяамаа: Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэх комисстой. Ажлаа хагас жилээр төлөвлөсөн. Бүх багш нар өөрсдийн чаддаг дугуйлангаа ажиллуулдаг. 28 дугуйлан хичээллэж байна. “Миний хобби”, “Бид ангиараа” анги бүр өөрийн онцлогтоо тохируулан чаддаг зүйлтэй болох зорилттой ажиллаж байна.
- Б.Шинэцэцэг: Багш бүр ажлынхаа хажуугаар хүүхдийг хөгжүүлэх гэж дугуйлан ажиллуулдаг. Эдгээр дугуйлангаас хамгийн сайн ажиллуулсан дугуйланд урамшуулал олгоно гэж ярьж байгаа урд оных дутуу ирсэн нэгэнт ажилласан нь үнэн юм чинь өгөх урамшууллаа цагт нь хасалтгүйгээр өгч баймаар байна.
- А.Нямдорж: 4-5-р ангийн 20 сурагчтай шатрын дугуйлан хичээллүүлдэг. Гэвч багшийн ажлын ямар ч үнэлгээнд ордоггүй. Дугуйлангийн тайланг улирал бүр эцэг эхэд тавьдаг.
- А.Нандинчимэг: Хөгжмийн дугуйлан хичээллүүлэхэд эцэг эхийн туслалцаа их хэрэгтэй болдог. Лимбэний дугуйлан хичээллүүлэх гэхээр хөгжмийн зэмсэггүй болохоор хэцүү байдаг. Авьяас хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг сургууль бүрт тэгш олгомоор байна захын сургууль болохоор орхигдоод байна уудаа.
- А.Мөнхцэцэг: Хүүхдийн авьяасыг тодорхойлох судалгаа үр дүнтэй болж чадаагүй. Дугуйлангийн урамшууллыг багш бүрт олгодог байх.Сургуулийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхэд хөгжүүлэх зардлыг тусгаж оруулах хэрэгтэй. Хөтөлбөрийн хүрээнд ирдэг хөрөнгө оруулалтыг захын сургууль гэж ялгалгүй олгодог баймаар байна.
- Д.Намсрай: хөтөлбөрийн хүрээнд авсан анхны судалгаа нь цаас барсан ямар ч үр дүнгүй богино хугацаанд багш,сурагч,эцэг эхчүүдийг бөглө гэж шахсан тийм л судалгаа болсон шүү дээ нэгэнт хөтөлбөр хэрэгжиж байгаа юм чинь бодитой судалгаанд түшиглэж хүүхдийн сонирхол хэрэгцээг тодорхойлмоор байгаа юм.

Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн багш нар

- Багш Долгормаа: “ Авьяас” хөтөлбөрийн дугуйланд бага ангиас хамрагдах сурагчдын тоо бага, багшийн хүрэлцээ муу байгаа. Бага ангийн багш нар өөрсдөө анги ангидаа чаддаг чаддагаараа л дугуйлан хичээллүүлж байна.
- Багш Мөнхгэрэл: “ Авьяас “хөтөлбөр анх хэрэгжиж эхлэхэд авсан судалгаа бодитой биш эцэг эхчүүдийн авьяасын талаарх ойлголт муу байснаас болоод хүүхэд эцэг эхчүүд хүүхдээ зөв тодорхойлж чадаагүй.
- Багш Оюунтуяа: Гол нь хүмүүсийн авьяасын талаар ойлголт ямар байна гэхээр авьяасыг зөвхөн дуулж бүжиглэх, эсвэл спортын тал дээр авьяастай байдаг гэж ойлгож судалгаагаа бөглөсөнтэй холбоотой
- Нийгмийн ажилдтан Д.Уртнасан: Авьяас хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дээрээ олон нэрт хүмүүсийн бүрэлдэхүүнтэй байсан гэтэл тэр хүмүүс нь яг анхан шатанд нь ирж хэрэгжүүлэх шаардлагатай байна багш бид хэрэгжүүлээд байгаа боловч ямар хэмжээнд ямар шалгуураар хүүхдүүдээ хөгжүүлээд байгаад үнэлэлт дүгнэлт байдаггүй юм. Хөтөлбөрийн сургалт хариуцсан олон одод байдаг тэдгээр хүмүүс хөдөө ирж туршлагаа түгээн дэлгэрүүлэх авьяас хөтөлбөрийн талаар ТВ-р цагтай болмоор санагддаг.

Хэрлэн сумын “Шинэ хөгжил” цогцолбор сургуулийн багш нар

- Багш Сайнжаргал: “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа үр дүнгүй цаасны гарз болсон.
- Багш Одбаатар: Жилд нэг удаа олгодог 10 сая төгрөг аль сургууль авсан нь ч мэдэгдэхгүй, мэдээлэл байдаггүй.
- Нийгмийн ажилтан Найдалмаа: 10 саяын дэмжлэгийг хувааж бус бөөнөөр өгөх хэрэгтэй. Гол нь юм хийхээр зүтгэж байгаа, ажил хийж байгаа сургуулиудаа олж өгөх хэрэгтэй. Дэмжлэг

авчихаад үр дүнтэй зарцуулахгүй, юм хийхгүй байвал яахав. Олгох шалгуур нь тодорхой байх хэрэгтэй байна

- Багш Наранбаатар: Үндсэн секц дугуйланд ямар ч урамшуулал байдаггүй. Сайн багш байж хүүхэд хөгждөг. Яг хүүхдээ хөгжүүлж чадаж байгаа багш нартаа урамшуулал өгөх хэрэгтэй. Тухайн багш хичээллүүлэх дугуйлангийнхаа талаар төсөл бичиж үр дүнг нь мөн тайлагнадаг байх хэрэгтэй. Сургууль урамшуулал олгох секц дугуйлангаа ил тод сонгон шалгаруулдаг байх хэрэгтэй.
- Багш Энхтунгалаг: Хөтөлбөртэй холбоотой мэдээлэл дутмаг байдаг. Санхүүгийн дэмжлэг олгох дүрэм журам тодорхой бус байна. Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа хугацааны хувьд маш богино байсан.
- Багш Наранбаатар: Ахлах ангийн сурагчдын дунд Фэйсбүүкийг хязгаартай хэрэглэх, эсвэл бүр хаах хэрэгтэй. Хүүхдүүд солонгосын олон ангит кино үзэж байхын оронд Монголынхоо түүх соёлыг харуулсан хүүхдүүдийн сонирхол хэрэгцээнд нийцэхүйц кино хийж гаргах хэрэгтэй.
- номтой нөхөрлүүлэх үйл ажиллагаагаа хамтад нь зохион байгуулах гэх мэт олон хэлбэрээр шинэлэг байдлаар хийж хэрэгжүүлэх боломжтой.
- Багш Цэцэгжаргал: Хөтөлбөрийг дүгнэх эргэх холбоо, хяналт байдаггүйгээс багш нарын ажлын эрч хүч буурах хандлага ажиглагддаг. Багш нарын ажлын ачаалал хэтэрхий их байна
- Багш Баярхүү: Авьяас хөтөлбөрийн хүрээнд өгдөг 10 сая төгрөгийн дэмжлэгийг манай сургууль аваагүй. Ямар нөхцөл шалгуураар олгодог нь тодорхой бус, мэдээлэл бага байна. Хөтөлбөрийн хүрээнд сургууль бүрийн хэрэглэгдэхүүн, нөөц боломжийн судалгааг гаргаж түүнд нь үндэслэн санхүүгийн дэмжлэгийг олгож байх хэрэгтэй

Баянтүмэн сумын сургуулийн багш нар

- Захирал Т.Сугаржав: Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад төсөв хөрөнгийн асуудал тулгамддаг. Манай сургууль хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалт ирээгүй бид сум орон нутгийн удирдлагуудад санал тавьсаар л байдаг юм.
- Багш Бямбасүрэн: “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд 5 чиглэлийн дугуйлан хичээллэж байгаа. Энэ хичээлийн жил тусдаа 1 багш 3 дугуйлан хариуцан хичээллүүлж байна. Хичээлийн жилийн төгсгөлд урамшуулал нь ирэх үгүй нь тодорхойгүй л байна.
- Нийгмийн ажилтан Оюун-Эрдэнэ: Манай сургууль сумын захиргаанд хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх санал тавьсан. Хүүхдийг хөгжүүлэхэд материаллаг бааз, хөгжмийн зэмсэг хэрэглэгдэхүүн байдаггүй хөдөө учраас учир дутагдалтай л дугуйлан хичээллүүлж байна.

Чойбалсан сумын сургуулийн багш нар

- Спортын чиглэлээр: Бөх, гар бөмбөг, ширээний теннис, бадминтон, хөл бөмбөг, шатар, шагай харваа
- Урлагийн чиглэлээр: дуу, бүжиг, спорт бүжиг, үндэсний хөгжим, уран уншлага
- Урлалын чиглэлээр: зураг, хайчилбар, шүрэн урлал, эсгий урлал, байгаль хамгаалал дугуйлан, секц хичээллэж байна. Багш нар хичээл сургалтынхаа хажуугаар хүүхдүүдийг хөгжүүлэх гээд дугуйлан ажиллуулдаг боловч ямар ч нэмэгдэл хөлсгүй ажилладаг. Энэ тал дээр анхаарах хэрэгтэй байна. Гол нь хүмүүсийн авьяасын талаар ойлголт ямар байна гэхээр авьяасыг зөвхөн дуулж бүжиглэх, эсвэл спортын тал дээр авьяастай байдаг гэж ойлгож судалгаагаа бөглөсөнтэй холбоотой байх судалгааг бодит авч чадаагүй зөвхөн асуулт бөглөөд орхисон шүү дээ.
- Багш Баярхүү: Авьяас хөтөлбөрийн хүрээнд өгдөг 10 сая төгрөгийн дэмжлэгийг манай сургууль аваагүй. Ямар нөхцөл шалгуураар олгодог нь тодорхой бус, мэдээлэл бага байна. Хөтөлбөрийн хүрээнд сургууль бүрийн хэрэглэгдэхүүн, нөөц боломжийн судалгааг гаргаж түүнд нь үндэслэн санхүүгийн дэмжлэгийг олгож байх шаардлагатай байна.

Бага ангийн багш нартай хийсэн ярилцлага

1 дүгээр сургууль

- Багш Мөнхөө : 1 ангид 20 гаруй, 1 төрлийн ном 2-3 ширхэг, 3-р ангид арай олон 49 ном ирсэн. 5-р ангийн ном нь их хүнд туульс, Алтан товч, 32 модон хүний үлгэр гэх мэт хүүхдийн насанд нь тохироогүй номнууд ирсэн
- Багш Урнаа: Хүүхдэд гэрт нь өгч явуулдаг. Зарим ном нь эргэж ирдэггүй.
- Багш Сүхээ: Бид нар хичээлийн агуулгаа эзэмшүүлэх гэж ядаж байхад иймэрхүү олон төрлийн хөтөлбөрт ажлууд нэмэгдэж орж ирдэг. Энэ нь багш нарт үнэхээр хүндрэлтэй байна.
- Багш Чулуун-Эрдэнэ: Том жижиг ном их хийсэн. Том номын хувьд материал их ордог дахин ашиглагддаггүй учраас үр дүн бага байдаг юм.
- Багш Ганчимэг: Уншихын хичээлийн цаг тусад нь гаргаж өгөх хэрэгтэй байна.
- Багш Отгонцэцэг: Төсөлт ажлын цаг юмуу эсвэл тусад нь цаг гаргаж ном унших цаг оруулах хэрэгтэй. Агуулга нь зөв боловч хэрэгжүүлэх арга хэлбэр нь биш байна. Багш нарт 2 цагийг ч юмуу хөтөлбөрийн хүрээнд бичдэг болвол зүгээр байна. Аймаг орон нутгийн хэмжээнд хүмүүжлийн ач холбогдолтой 1 ном зохиолыг сонгож нийтээрээ унших хөдөлгөөн өрнүүлэх, орон нутгийн мэдлийн цагаас хөлсийг нь шийдэх гэх мэт гарц байж болно.
- Багш Сүхтогоо: Хүүхдэдээ үр дүнтэй байдлаар явуулах хэрэгтэй. Үргэлжилсэн үгийн номыг хүүхэд авч унших дургүй. Нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх хэрэгтэй.
- Багш Сувдаа: Цаг гаргаж өгөх л хэрэгтэй.
- Багш Отгонцэцэг: Хөтөлбөрийн давуу тал нь хүүхэд номонд дуртай , сурах бичгээр хязгаарлагдахгүй номын сантай харьцаж сурч байгаа сайн тал байгаа юм.

2-р сургууль

- Нандин-Эрдэнэ :номын хүртээмж муу байна. Сургуулийн номын сангаар ирж байгаа ном нь хүүхдийн насны онцлогт тохирохгүй өөрт нь томдсон ном ирдэг. Хүүхдүүд гэрээсээ ном цуглуулж номын сангаа баяжуулдаг боловч дандаа хэрэглэгдэхээгүй номнууд ирдэг юм.Уншсан номоороо тэмдэглэл хөтлөхдөө гол санаа, амьдралд хэрэгжүүлэх санаа, өөрийн бодол, дүгнэлт гэсэн 4 чиглэлээр хөтөлдөг.
- Ж.Ганчимэг: Бага ангийн хувьд өнгөрсөн жил сар сардаа ангиараа хариуцаж үйл ажиллагаа зохион байгуулдаг байсан. Энэ жил анги ангидаа зохион байгуулж байгаа. Ер нь ном унших 1-р ангийн хувьд уншиж чадахгүй болохоор хүндрэлтэй байна. Өөрөө уншиж өгөөд ярилцлага хийдэг.
- Булгантамир: Номын хүртээмж муу байдаг. Дунд 3 бүлэгтэй. Сард унших номын тоо 2, 3 л байдаг болохоор бүрэн уншиж амждаггүй.
- Гэрэлтуяа: Зарим анги номоо аваад нэг хэсэг өгдөггүй. Сар дуусахад 4,5 хоногийн өмнө номоо олж авдаг. Тийм болохоор ангийн бүх хүүхэд уншиж чаддаггүй юм.
- Түвшинжаргал: номын хүртээмж муугаас 2,3 хүүхэд дамжуулж уншаад ангийнхандаа ярьж өгдөг.
- Өсөх-Ирээдүй: Заримдаа уншсан номоороо тэмдэглэл хийхгүй зургаар илэрхийлдэг , том ном хийх нь ашиггүй зардал их гарах юм.
- Энхзаяа: хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон ном их цөөн байна. Номын сонголтыг заримдаа хүүхдүүдээс авбал тэдний хэрэгцээ сонирхолд нийцэх болно.
- Одсүрэн: Хүүхдүүд уншсан номоороо тэмдэглэл хийх, АХА, Алтан хонх тэмцээн зохион байгуулсан.
- Батсайхан: “Ном” хөтөлбөрийн хэрэгжилт дунд зэрэг байгаа. Ахлах ангийн сурагчид ном уншиж эсээ бичдэг ч багш нар хүүхдүүдтэй ажиллах цаг зав бага байдаг. Номын хүртээмж муу байдаг.
- Э.Эрдэнэчимэг: ахлах ангийн сурагчид хичээлийн 5 өдөр бүтэн сонгох хичээлтэй байдаг. Цаг бага байдаг.
- О.Учрал: Номын сангаар дамжин ирж байгаа ном нь тухайн ангийн сурагчдад ахадсан номнууд ирж байгааг уламжилж болдоггүй юм уу
- А.Мөнхдаваа: номыг хүүхдийн насны онцлогт тохируулан нийлүүлэх шаардлагатай байна.
- Батсайхан: “Ном” хөтөлбөрийн хэрэгжилт дунд зэрэг байгаа. Ахлах ангийн сурагчдад унших ном нь хүртээмжгүй номын хангамж муу байна.

Хан-Уул цогцолбор сургууль

- Сургалтын менежер М.Цогзолмаа: Манай сургууль 3 дахь өдөр бүрийн 12.30-д анги бүр “Уншлагын цагтай” тусгай цаг гаргаж өгсөн. Хүүхдүүд сургуулийн номын сангаараа тогтмол үйлчлүүлдэг, нэг анги маань аймгийн төв номын санд ангиараа карт нээлгэж уншигч болсон, 4-р сард уншсан ном зохиолоороо “Дүрийн тоглолт” –ын уралдаантай.
- Багш Д.Баярхүү: “Ном” хөтөлбөрийн хүрээнд ирсэн 32 номыг 2 анги дундаа хэрэглэдэг. Номын хүрэлцээ муу байна. Нэг төрлийн ном 2-3 ширхэг байдаг учраас анги нийтээрээ тухайн 1 номыг судалж ярилцах боломжгүй байдаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тусгайлсан цаг байдаггүй, хичээлээс гадуур цаг зав гаргах шаардлагатай болдог.
- Багш Батцэцэг: Ном хэтэрхий олон хуудастай байгаа нь 1-р ангийн сурагчдад тохиромжгүй байна. Хөтөлбөрийн хүрээнд том, жижиг номыг хийж байгаа. Эцэг эхчүүдтэйгээ хамтраад 3 том номтой болсон. Том ном олныг хийх боломж багатай. Эцэг эхчүүдийн цаг зав хомс, жижиг номыг 4-5 дугаар ангийнхан л өөрсдөө хийхэд арай дөхөмтэй 1-3 дугаар ангийнхан яг биеэ дааж хийхэд хүндрэлтэй байдаг.
- Багш Доохүү: Багш нар хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хичээлээс гадуур уншлагын цаг гаргаж илүү цагаар ажиллах шаардлагатай болдог.. Эцэг эхчүүдийн боловсролын түвшингээс шалтгаалаад хөтөлбөрийн талаар ойлголт мэдээлэл харилцан адилгүй учраас хүүхдэд гарах үр дүн бага байна.
- Багш Баярхүү: Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ багш, эцэг эх, сурагчийн үүрэг ийм байна гэж нарийн тодорхой зааж өгөх хэрэгтэй. Тэгээд түүнийгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр сайн сурталчилж өгвөл хөтөлбөрийн үр дүн гарна.
- Багш Батцэцэг: Энэ жилийн 4 дүгээр ангийн ном маш зузаан хүүхдүүдийн сонирхлыг татахгүй байна. Заавал олон төрлийн ном байх шаардлагагүй. 4-5 төрлийн хүүхэд бүрт хүртээмжтэй байвал илүү үр дүнтэй. Улиралд анги нийтээрээ 1 номыг чанартай уншиж судлан унших арга барилд суралцах нь чухал гэж бодож байна. Яахав тэдгээр номноос нь гадна хүүхэд чөлөөт цагаараа унших ганц нэг төрлийн нэмэлт ном байж болох юм.
- Багш: Бага ангийн багш нарын хувьд олон төрлийн хичээл ордог ажлын ачаалал их байдаг. Ямар нэгэн хөтөлбөр хэрэгжүүлэхдээ үүнийг нь бас давхар тооцож байх хэрэгтэй.

5-р сургууль

- “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг баг ажилладаг.”Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жилээр хийдэг. Ажлаа мэдээллийн самбар дээр гаргадаг.
Ололттой тал: “Ном” хөтөлбөр хэрэгжснээр хүүхдүүдэд тодорхой мэдлэгийг олгож байгаа.
- 3-р ангийн секц энэ улиралд хэрэгжүүлж байгаа. Ховор номын үзэсгэлэн, шүлэг, зургийн уралдаан зарласан. Манай сургуулийн багш нар өөрсдийн чадварт тулгуурлан хүн болгон дугуйлан хичээллүүлдэг. Гэхдээ ямар ч урамшуулал авдаггүй.
Дутагдалтай тал:
- Бага ангийн багш маш ачаалалтай ажилладаг.
- Ном уншуулах цаг, зав байдаггүй
- Ангийн номын сангийн номнууд хүүхдийн насанд тохироогүй. Жнь: “Хорвоотой танилцсан түүх” 2-р ангийн ангийн номын санд байдаг. Номын агуулга муу.
- Том, жижиг ном хийдэг боловч ашиглалтын хувьд тааруу. Эдийн засгийн хүндрэлтэй.
- Номын богц хийхэд эцэг эхийн чадвар дутмаг. Хөрөнгө мөнгө их шаардагддаг.
- Ангийн номын сангаар ирсэн номын төрөл нь олон боловч цөөн тоогоор ирсэн.
- Ангид байхад сурагчид уншиж байгаад ном алга болгох, ураг явдал гардаг.
Санал:
- “Ном” хөтөлбөрийн ангийн номын санг сургуулийн номын санд төвлөрүүлж, тэндээс олгодог байх. Номын санч энэ ажлыг хийдэг байх. Тэндээс үйл ажиллагааг зохион байгуулж ангиуд оролцдог байх Ном хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш нарт урамшуулал олгох

8дугаар сургууль

- **1дүгээр ангийн багш нартай ярилцлага** Ном хөтөлбөрийн хүрээнд ангийн номын санд ном ирсэн. 1дүгээр ангийн хүүхдийн нас сэтгэхүйд тохироогүй хэтэрхий олон хуудастай.
- Хөтөлбөрийн хүрээнд ангидаа том жижиг номыг хийж байгаа нь 1-3-р ангийнхан биеэ дааж ном хийнэ гэдэг бол хэцүү, эцэг эхчүүд ч тэр бүр тусалж чаддаггүй
- Хүүхдүүддээ номыг нь уншиж өгч ойлгож байгаа эсэхийг нь зургаар зуруулж байна мөн шүлэг цээжлүүлдэг хэдий ч багш нарт илүү цаг зав их шаарддаг юм. Хүүхэд өнгөт номонд дуртай байдаг.
- 1дүгээр ангийн ном нь өнгөт зурагтай түүнийгээ будаж бүтээх ажилтай байвал хүүхдэд илүү ойлгомжтой болох юм. Нийлүүлэгдэж байгаа номыг анхаарч хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг

харгалзан багш нараас судалгаа авч хэрэгцээ шаардлага хангасан ном нийлүүлэх нь зүйтэй байна

2дугаар ангийн багш нартай хийсэн ярилцлагаас

- Ном хөтөлбөрийн хүрээнд 22 төрлийн 44 ном сургуулийн номын сангаар дамж дамжуулан ангийн номын санд ирсэн. Ангийн сурагч бүр уншлагын карттай ба 2дугаар ангий ангийн сурагчид ном уншихад их цаг хугацаа шаарддаг учраас хичээлийн бус цагаар уншлагын цаг гарган уншуулдаг.
- Ангийн том ном: хүүхдүүд номын агуулгыг товчлон, таамаглал дэвшүүлэх хэсэгт зогсоц, . . .хэрэглэх багш, эцэг эх хамтран бүтээж болдог. Хүүхдүүд уншсан номын агуулгыг зургаар дүрслэн илэрхийлж тэмдэглэл хийдэг
- Ангийн жижиг ном: хүүхдүүд өөрийн болсон үйл явдал дээр тулгуурлан зургаа өөрсдөө зурж будаж бүтээдэг. Хүүхдүүд өөрийн номоо зургаар илэрхийлж будах дуртай байгаа нь хүүхдийг танин мэдэхүйн ном уншуулах өөрөөр хэлбэл өнгө будагтай номонд илүү дуртай байгаа нь ажиглагдаж байгаа юм.
- Мөн ангийн сурагчид номтой нөхөрлөснөөр ном унших сонирхолтой,бичих зохиох чадварт илүү ахиц гарч байна. Хүүхдүүд шүлгээ цээжилж анги хамт олноороо массаараа зэрэг уншиж сурсан нь тэднийг хамт олонч болж төлөвшихөд илүү нөлөөтэй нь харагдаж байгаа юм.
- Гэвч зарим номын хэмжээ их, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохироогүй номнууд бас байдаг.Иймд бага насны хүүхдэд өнгө будаг будах, будаж бүтээх, нас сэтгэхүйд нь тохирсон танин мэдэхүйн чиглэлийн ном байвал илүү ойлгомжтой хүртээмжтэй болох юм. Ангийн ном хийх гэж маш их цаг хөдөлмөр зарцуулдаг мөн маш их цаас ордог гэтэл үүнийг эцэг эхчүүд ойлгодоггүй

3дугаар ангийн багш нарын ярилцлага

- Хүүхдүүд багш нар ангийн номын сангаар олгогдсон номнуудыг бүрэн дүүрэн ашиглаж байгаа гэвч гадаадын зохиол бүтээл нь үг хэллэгийн хувьд шаардлага хангахгүй байна.Жнь: Цагаан соёот,Пиноккио модон хүүгийн үлгэр гэх мэт номнуудыг хүүхэд сонирхдоггүй . Харин Бэмби ба ойн амьтад гэх мэт үлгэрийн зурагтай номнуудыг амтархан уншдаг. Сурагч бүр уншлагын карттай . Эцэг эхчүүд хүүхдүүддээ хүмүүжлийн сэдвээр ном уншиж өгдөггүй ер нь номын сантай айл ховор болж байна. Зарим эцэг эхчүүд ном уншихыг зөвхөн багшийн үүрэг мэт ойлгодог хандлага нь сурагчдад нөлөөлж байдаг юм. Зарим тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ гэхээсээ илүүтэй өөрсдөө боловсрол дутуу хандлага буруугаас хүүхдийнхээ хичээл номонд анхаардаггүй багш бараг тэдэнтэй ажиллах шаардлага ч гардаг .
- Бага ангийн сурагчид хэт зузаан ном уншиж чадахгүйгээс гадна гадаад үгтэй өгүүллэг бүтэн уранзохиолын роман ч байна. Энэ нь тэдний сэтгэхүйн онцлогт тохирохгүй байна.
- Хүүхэд богино хэмжээний ,зурагтай ном сонирхож уншихаас гадна монгол ардын үлгэрийг унших дуртай түүгээрээ дүр бүтээж тоглох нь тэдний хувьд бахархал байдаг нь харагддаг.
- Иймээс хүүхдэд өөрийнх нь нас сэтгэхүйд тохирсон сонирхолтой номнуудыг сургуульд нийлүүлж байвал үр дүн нь ч сайн байна шүү дээ.
- Ангид ангийн номын сангаас гадна том ,жижиг ном гэж бий. Том ном гэдэг нь багш хүүхдийг номонд дуртай болгох сэдэлжүүлэх ажлыг уншлагын явцад болон ном бүтээх үйл явцад хийдэг ба хүүхэд өөрөө 40-45%-г бүтээдэг . Харин жижиг номыг хүүхэд өөрт тохиолдсон болсон үйл явдал,амралт аялал,адал явдал зэрэг хөгжилтэй агшнуудыг ном болгон бичдэг юм.Мөн өөрийн зохиосон шүлэг,дуу ч байж болдог юм.
- Хүүхэд жилд ангийн номын сангаар дамжиж ирсэн 25 төрлийн номыг 1 хүүхэд улиралд 3-5-ийг уншдаг бөгөөд жижиг ном 200гаруйг уншиж танилцсан байдаг юм. Номны хүртээмжийн хувьд боломжийн боловч шаардлага хангасан ном хэрэгтэй байна. Цаашид номын сантай айл өрхийг шалгаруулдаг байвал хүүхдүүд номонд дуртай болохоос гадна өөрсдөө бүтээл хийснээр хэл ярианы хөгжил болон тэдний идэвхи төлөвшилд ахиц гарна

4дүгээр ангийн багш нарын ярилцлагаас

- Ном хөтөлбөрийн хүрээнд ангийн номын санд нийт 32 төрлийн 63 ширхэг ном хуваарилагдан ирсэн нийт номын жагсаалтыг таниулахаас гадна сурагчдад унших хуваарь гарган карт нээн уншуулдаг. Сурагч бүр ангийн номын сангаас жилийн хугацаанд нийт 32 номыг шинээр уншиж жижиг ном нийт 200 гаруйтай танилцаж байна. Сурагч бүр уншсан номынхоо тэмдэглэл хийж багшдаа болон анги хамт олондоо ярьж өгдөг юм.
- Ангийн номын санд том ном, жижиг ном гэж байдаг .

- Том номонд үлгэрийн номнууд орохоос гадна дүрийн болоод жүжигчилсэн тоглолт,шүлэг цээжлэх,анги нийтээр шүлэг цээжилж унших мөн аймгийн зохиолчдын уран бүтээл болох ном,шүлгүүдээс уншиж цээжилж хоорондоо ярилцдаг. Жнь: 4дүгээр ангийн сурагчид Дорнод аймгийн Эрэнцавын зохиолч Д.Нямсүрэнгийн “Дөрвөн цаг” шүлгийг 3 бүлгийн сурагчид массаараа цээжилж уран уншиж сурсан .
- Жижиг ном нь хүүхэд өөртөө тохиолдсон хөгтэй явдал болоод баяр хөөртэй үйл явдлаа бичиж ном болгоно. Жижиг номыг хүүхэд гэртээ хийх ба эцэг эхчүүдтэйгээ хамтран ярилцаж хийснээр хүүхэд өөрийн уран бүтээлдээ хайртай ном хийх дуртай байгаа нь ажиглагддаг юм. Цаашид хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон номнуудыг нийлүүлдэг байвал хүүхдийн хөгжилд илүү нөлөөлнө..

5дугаар ангийн багш нарын ярилцлага

- Сургуулийн номын сангаар дамжин ангийн номын санд ирж байгаа ном нь нас сэтгэхүйн онцлогт тохироогүй номнууд байдаг. Жнь: Монголын сэтгэхүйг ариусгахуй,Ногоон дарь эх,Цагаан дарь эх ,Жангар гэх мэт зарим номнууд хүүхдэд уншихад хүнддэж байна.Хүүхдэд бага хэмжээний сонирхол татахуйц жижиг жижиг өгүүллэгүүд байвал зохимжтой.
- Ангийн номын сангийн ном нь хэллэг хүнд дээшээ ангиудад үзэх номнууд ирж байгаа ба 2дугаар ангийн тайлбар толийг гэхэд 5 дугаар ангид үзэх жишээтэй байна л даа. Хүүхдүүд ангидаа том номыг өөрсдөө бүтээдэг жижиг номыг өөрт тохиолдсон адал явдал болон 4 мөрт шүлэг гэх мэт өөрийнх нь бүтээл байдаг юм.
- Хүүхдүүд нийт 36 төрлийн том ном унших ба хичээлийн жилийн хугацаанд 200 гаруй жижиг номыг бүтээж ажиллаж байна. Ангидаа ном уншуулахаас гадна гэрээр ном өгч уншуулдаг. Эхний жилд ангидаа том ном,жижиг ном өөрсдөө бүтээж байсан дараагийн жилээс ангид ном ирсэн.
- Номын хүртээмж хангалттай байгаа боловч номын чанар нь зарим тохиолдолд шаардлага хангахгүй байна. Хүүхэд хичээлийн жилд нийт дээ 1 улиралд 9 ном уншина ер нь улиралд чанартай 2-3 ном байхад л хангалттай шүү дээ.
- Жангар туужийг өнөөдөр гэхэд 11-12дугаар ангид үзэж байгаа шүү дээ. Тиймээс хүүхдэд ойлгомжтой үг хэллэг яруу тод, бага хэмжээтэй танин мэдэхүйн,сэтгэхүй хөгжүүлэх номнуудыг түлхүү байвал үр дүнгээ өгч чадна гэж боддог юм.
- Бага ангийн хүүхэд ер нь том номонд сонирхолгүй нимгэн , зурагтай танин мэдэхүйн болоод оньсон техникийн ном их сонирхон уншиж байна

11-р сургууль

- А.Мөнхцэцэг: Манай сургууль 2 ээлжтэй болохоор гэрээр уншуулдаг. Цаашид ном уншуулах цагийг хичээлийн хуваарьт оруулах эсвэл цаг гаргаж өгөх. Багш нарын ажлын ачаалал ихтэй байдаг. Номнууд нь хүүхдийн хэрэгцээ шаардлагыг хангадаггүй.
- Т.Сарангэрэл: Том, жижиг ном хийхэд эдийн засгийн хувьд хүндрэлтэй байдаг.
- Г.Ганчимэг: “Ном” үр дүнтэй хөтөлбөр. Эхний жил их сайн хэрэгжсэн. Хүүхэд зохиолчийн намтар, уран бүтээлтэй танилцаж байна. Ангид танхимын хүрэлцээ муу. Хүүхдүүд уншсан номоор дүрийн тоглолт, ярилцлага хийх боломжгүй байдаг. Дунд ангийн унших ном олдоц муутай байдаг.
- А.Мөнхцэцэг: Зурагтай, комекс номонд хүүхдүүд дуртай байдаг. 32 модон хүний үлгэрийг хүүхэд ердөө ойлгодоггүй. Хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон ном шаардлагатай. Том номны ач холбогдлын талаар тооцож үзэх шаардлагатай.
- А.Нямдорж: Ангийн номын санд яг хүүхдийн сонирхол татсан, нас сэтгэхүйд нь тохирсон ном цөөн
- Номын санч Эрдэнэчимэг: Ном хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсэгтэй байдаг. Бага ангийн сурагчид унших номтой болохоор боломжтой. Унших номын нэр, уншлагын цагийн хуваарь гаргасан. 14 хоногт 1 удаа 3 дах өдөр уншлага, хүмүүжлийн ажлаа хийдэг. Унших номын тоо цөөн байдаг.
- Б.Шинэцэцэг: Уншлагаа АУБ нар ангидаа хийдэг. Тайлангаа улирал бүр эцэг эхдээ тавьдаг. Багш, ажиллагсдын унших номын жагсаалт гаргасан. Улиралд нэг удаа шалгаруулах эсээ бичлэгийн уралдаан зарласан

12 дугаар сургууль

- Сургалтын менежер М.Хараа: Манай сургууль энэ хичээлийн жилд анги бүр “ Хүүхэд хөгжлийн цаг”-ийг хэрэгжүүлж байгаа.Түүгээрээ дамжуулан сурагчдыг номтой нөхөрлүүлэх төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Хүүхдүүд сургуулийн болон аймгийн номын сангаар тогтмол үйлчлүүлдэг.
- Багш Г.Оюунтуяа: “ Ном” хөтөлбөрийн хүрээнд ирсэн номыг 2 анги дундаа хэрэглэдэг. Номын хүрэлцээ муу байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх тусгайлсан цаг байдаггүй, хичээлээс гадуур цаг зав гаргах шаардлагатай болдог.
- Багш Мөнхгэрэл: Ном хэтэрхий олон хуудастай байгаа нь 1-р ангийн сурагчдад тохиромжгүй байна. Хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон номыг олж нийлүүлэх хэрэгтэй байна.
- Багш Дарьханд: Хөтөлбөрийн хүрээнд том, жижиг номыг хийж байгаа. Эцэг эхчүүдийн цаг зав бага байдаг учраас тэр бүр хийж чаддаггүй. Бага ангийн 1-3 дугаар ангийхан яг биеэ дааж том жижиг ном хийхэд хүндрэлтэй байдаг. Эцэг эхчүүдэд “ Ном” хөтөлбөрийн талаар ойлголт сайн өгөх хэрэгтэй.
- Багш Олонбаяр: Багш нар хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хичээлээс гадуур уншлагын цаг гаргаж илүү цагаар ажиллах шаардлагатай болдог. Бага ангийн багш нар маш их ачаалалтай ажилладаг. Энэ ачааллыг багасгах хэрэгтэй.
- Багш Мөнхгэрэл: Ямар нэг хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ багш нарын ажлын ачааллыг тооцож байх хэрэгтэй. Ганцхан багшийн ажил биш эцэг эх, сурагчийн хамтын ажиллагааны үндсэн дээр амжилттай сайн хэрэгжих ёстой гэдгийг сайн анхаарах шаардлагатай байна. Эцэг эхчүүд хөтөлбөрийн талаар ойлголт мэдээлэл байхгүйгээс болоод хүүхдэдээ тусалж чаддаггүй хөтөлбөрийн талаарх мэдээллийг орон нутгийн тв-р цаг гарган явуулж байх нь зүйтэй

“Шинэ хөгжил” цогцолбор сургууль

- Багш Цагаанхүүхэн: Ном хөтөлбөрийн хувьд ирсэн ном нь хүүхдийн насанд тохироогүй. Бага насны хүүхдүүдэд бичиг нь том, зураг голлосон байх хэрэгтэй.
- Багш Д.Туяа: Ном нь хүрэлцээгүй. Номоо уншаад ангиараа ярилцах цаг байдаггүй. Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд л ордог. Тэр нь 7 хоногт 1 цаг байдаг.
- Багш Одбаатар: 1 цагийн хугацаанд хүүхдүүд бүрэн унших боломжгүй байдаг. Гэрт нь уншуулахаар өгч явуулдаг боловч хүүхдүүд гэртээ уншихгүй ирдэг.
- Багш Болорцэцэг: Эцэг эхчүүдийн хариуцлага сул байгаагаас хүүхдүүдээ гарт нь ном өгч уншуулахад хүндрэлтэй байдаг.
- Багш Сайнжаргал: Бага ангид монгол хэл, уншихын хичээлийг салгаж өгөх хэрэгтэй. 2 ээлжээр хичээллэж байгаа учраас үдийн дараа анги танхим хүрэлцэхгүй , хүүхэдтэйгээ ажиллах боломж бүрдэхгүй байна.
- Багш Цагаанхүүхэн: Багш нар ажлаа дүгнүүлж шалгуулахдаа хүүхдүүдийнхээ монгол хэл, цээж бичгээр шалгуулдаг болохоор шалгуулдаг тэр зүйлээ л илүү их давтахаас биш унших хичээлийг орхигдуулдаг талтай.
- Багш Д.Туяа: Тийм болохоор унших хичээлийг тусад нь болгож хөтөлбөрт оруулж өгөх хэрэгтэй.

Баянтүмэн сумын сургууль

- Захирал Т.Сугаржав: Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад төсөв хөрөнгийн асуудал тулгамддаг. Төр, орон нутгийн удирдлагуудад энэ талаар санал өгөх, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах шаардлага байнга гарч байдаг юм. Манай сургуульд одоогоор ном хөтөлбөрийн ном ирээгүй урд нь 2008 онд “ READ” төсөл хэрэгжсэн учраас энэ төсөлд түшиглэн ном хөтөлбөр хэрэгжиж байгаа гэж ойлгож байгаа.
- Багш Мөнхтунгалаг: Бага ангийнхны хувьд ангийн номын сантай. Дунд ангийнханд ашиглах ном тааруухан, сургуулийн номын сангийн баяжилт хүрэлцээ муу бага ангид хүүхэд бүрт хүрэлцээтэй харин дунд ангийнханд унших ном хүртээмжгүй байгаа талаар уламжилж өгвөл сайн байна.
- Багш Осгонтуйа: 2008 онд “ READ” төслийн хүрээнд ангийн номын сан ирсэн. Төслийн хүрээнд анги бүрт 4 төрлийн 160 ширхэг ном өгсөн. Сүүлд нэмж 20-иод ном ирээд нийт 180 гаруй номтой болсон. “ Ном” хөтөлбөрийн хүрээнд тусгайлан ном ирээгүй байна.
- Багш Өнөржаргал: Анги ангиараа уншлагын цагтай. Уншсан номын тэмдэглэлээ хөтөлж явдаг.
- Нийгмийн ажилтан Оюун-Эрдэнэ: сургуулийн эцэг эхчүүдийн оролцооны хувьд хүүхдүүдийн эцэг эх нь хөдөө алс байдаг учраас 1 эцэг эх 3 хүүхдийг төлөөлж ирж байдаг юм. Манай

сургууль 100 хүүхэдтэй. Хүүхдүүд сумын номын сангаар үйлчлүүлэхэд бүрэн боломжтой тэдний эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн ном ховор байна.

- Багш Мөнхтунгалаг: Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа тэмцээн уралдааны шагнал урамшууллын асуудал ч хүнд байдаг. Багш нар хувиасаа мөнгөө нийлүүлж гаргадаг.

Ахлах дунд ангийн багш нар

1дүгээр сургууль

- Багш: Болормаа Дунд ангиуд ангийн номын сантай.
- Багш: Аймгийн номын сантай гэрээтэй. Дунд ахлах ангийн багш нарын унших номын жагсаалт гаргасан. Багш нар хоорондоо номоо солилцож уншиж байна..
- Багш Цэцгээ: Дунд ангийнхан том ном хийж сурсан.Түүгээрээ үзэсгэлэн гаргасан.
- Багш: Багш нар уншсан номынхоо талаар лекц уншсан.
- Багш: Саранчимэг багш facebook-ээр дамжуулан ном уншуулах талаар илтгэл бичиж илтгэлийн уралдаанд түрүүлж байсан.
- Багш Уянга: Хөтөлбөрийн санаа нь зөв боловч номын хүрэлцээ бага байна.
- Номын санч: Төсөв байхгүй учраас ном сонин шинээр авч чаддаггүй..

2дугаар сургууль

- Багш Б.Батцэцэг: Манай сургууль “Сард 1 ном, 1 эсээ”, “Өдөр бүр 20 минутын уншлага” аяны хүрээнд “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Багш, ажилтан, сурагчдын жилд унших номын нэрийг гаргаж байрлуулдаг. Сарын эцэст уншсан номоороо эсээ бичиж, хэлэлцүүлдэг.
- Дунд ангийн багш нар
- Л.Ганчимэг: Сар сардаа нэг анги нь хариуцаад явах нь үр дүнтэй юм байна. Энэ жилийн хувьд жаахан сул болсон. Хүүхдийн номын тоо цөөн болохоор хэцүү байна.
- Б.Энхнайрамдал: “Ном” хөтөлбөр хэрэгжүүлэх нь хүүхдийг ном уншиж сургахад зайлшгүй хэрэгтэй хөтөлбөр. Харин хэрхэн яаж хэрэгжүүлж хүүхдийг номонд дуртай болгох нь багш, эцэг эхийн ажил болоод байна.
- Б.Батцэцэг: Дунд, ахлах ангийн номын олдоц муу. Интернет, аймгийн номын сан, сургуулиудын номын сан гээд бүх л аргаар хайгаад хангалттай унших номоо олж чаддаггүй. Дээд тал нь 5 ном олддог. Ахлах ангийн хүүхдүүдийн цаг зав их бага байдаг. Сонгон, дугуйлан гээд цаг зав багатай байдаг.
- Д.Дайрийжав: Ахлах ангийн сурагчдад уншуулах ном олддоггүй. Цаг зав муутай байдаг. Уул нь ном уншуулж эсээ бичүүлж байх нь их дээд сургуульд ороход нь хэрэгтэй байдаг.

Чойбалсан сумын сургууль

- Захирал: Т.Одгэрэл “Ном” хөтөлбөрийг монгол хэл уранзохиолын багш нар , номын санч хариуцдаг. Манай сургууль дээр Дэлхийн банкны санхүүжилтээр ЯХИС-аас хэрэгжиж байгаа “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төсөл хэрэгжиж байна.Бага ангийн багш нар ангийн номын сантай түүгээрээ дамжуулан хүүхдүүддээ ном уншиж өгөх,ном бүтээх ажлуудыг хийж байгаа. Сургуулийн төсөвт номын баяжилт хийгдэх мөнгө байдаггүй учраас номны хүрэлцээ хүртээмж муу байдаг юм.
- Сургалтын менежер С.Азжаргал. Хүүхдүүддээ сургуулийн номын сан сумын номын сангаас ном авч уншуулдаг. Номын санч ангиудад заавал унших номын жагсаалт гаргаж өгч номоо уншуулдаг. Зарим номыг аймгийн номын сангаас захиалгаар авч уншуулдаг Багш нар хөдөө “Номтой аялал”-ыг зохион байгуулсан. Номоо уншиж дүрийн тоглолт хийсэн. “Номын сайн нөхөр” шилдэг сурагч, анги шалгаруулдаг. “Бид зохиолч”, “Би номын эмч”, “Уран зохиолын чуулган”, зохиолчдоор 7 хоногийн аян, эцэг эхчүүдийн ном унших ажлыг зохион байгуулах зэрэг олон ажлуудыг хийж байна.
- Багш.Ж.Наран хөтөлбөрийн хүрээнд ангийн номын сангаар ном уншуулах ажлыг зохион байгуулж байгаа
- Багш.Х.Даваасүрэн дотуур байрны сурагчдыг сумын номын санд ном уншуулах,сургуулийн номын сандаа ном уншуулж дүр бүтээн тоглолт хийлгэж бага ангийнханд үзүүлсэн
- Багш. Бага ангийн багш нар ном уншуулахаас гадна ангийн номын санд том,жижиг номыг бүтээж хэрэглэж байна.
- Сургуулийн төсөвт номын баяжилт хийгдэх мөнгө байдаггүй учраас номны хүрэлцээ хүртээмж муу

Нийгмийн ажилтнуудын ярилцлага:

1дүгээр сургууль: манай сургууль хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг аваад ажиллаж байгаа урд нь ингэж хөрөнгө оруулалт ирдэггүй байсан энэхүү дэмжлэг нь сурагчдын хөгжилд маш их дэмжлэг болж байгаа. Авьяас хөтөлбөрийг дуу хөгжмийн багш нар маань хичээллүүлж байна .ер нь багш нарын урамшууллыг цаг хугацаанд нь өгч байх нь зүйтэй

12дугаар сургууль: Манайх дэмжлэг аваагүй ямар шалгуураар өгдөг нь тодорхой бус сургуулийн үзэмжээр өгдөг юм уу . хөтөлбөрийн судалгаа үр дүнгүй болж өнгөрсөн судалгааны дагуу хүүхдийн авьяасыг хөгжүүлэх гэхэд байр танхимын хүрэлцээ муу хичээлийн ээлж таарахгүй хүүхдүүд хүссэн дугуйландаа суралцах боломжгүй байдаг.

8дугаар сургууль: Хөтөлбөрийн эхний жилийн санхүүжилтийг хүүхдийн тоо олон байгаа төвийн болон сумын нэг сургуулийг сонгож дэмжлэгийг олгосон. Харин дараагийн жил аль сургууль нь тодорхойгүй болсон уг нь сургуулийн судалгаанд суурилж аль болох техник тоног төхөөрөмж хөгжмийн зэмсэг дутмаг сургуульд олгомоор юм. Нэгэнт нийгмийн ажилтнууд авьяас хөтөлбөрийг сургууль дээрээ зохион байгуулж хариуцдаг учраас мэдээллийг тэнцвэртэй өгч баймаар байна. Авьяас хөтөлбөрийг эхний жил Л.Наранчимэг багш, дараа нь Б.Оюунбат мэргэжилтэн, одоо Ж.Насанжаргал мэргэжилтэн хариуцан ажиллаж байна. Ер нь хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн нь солигдох нь хөтөлбөрийн үйл ажиллагаа тогтмолжихгүй өмнө нь хийсэн ажлын залгамж холбоо байхгүй байгааг анхаармаар байна. Одоо аль сургууль дэмжлэг авах нь тодорхойгүй л байна.

Шинэ хөгжил сургууль: хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн хүрээнд ажиллаж байгаа нэрт од жүжигчид,дуучмид орон нутагт ирж ажиллавал үр дүнтэй тэд зөвхөн хотод ажиллаад байх юм.Тэдний туршлагыг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай

Дашбалбарсум Г.Болорцэцэг: Манайд 5 дугуйлан хичээллэдэг. Байр танхимын хүрэлцээ муу байна. Бүжгийн дугуйлангаа бололцоогоор нь клубт хичээллэдэг.

Матад сум Д.Тунгалаг: Хөтөлбөрийн хүрээнд анги бүр массаараа 10дуу сурсан.технологийн дугуйлан бусдаас илүү үр дүнтэй явагдаж байгаа. Хөтөлбөрийн хүрээнд ирж байгаа хөрөнгө оруулалт нь аль сургуульд олгогдож байгаа нь ил тод биш хөдөөний бидэнд мэдэлэл алга дэмжлэг авмаар л байна.

Чойбалсан сум: Ж.Даваасүрэн: Хөтөлбөрийн хүрээнд дугуйлангууд хичээллэж байна . Багш нарын урамшууллыг хасах биш хүний тоог нэмэх шаардлагатай

Цагаан –Овоосум Б. Батжаргал: Манай сургууль дэмжлэг авсан хүүхдэд үнэхээр хэрэгтэй харин багш нарын урамшууллыг багасгаж байгаад багш сэтгэл дундуур байдаг.

Баяндун сум Б.Бодисмаа: манай сургууль ИТХ-д асуудал оруулж сургуульдаа хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд 2сая төгрөгийг шийдвэрлүүлж хэрэгслээ авсан. Хүүхдүүд сонирхолтой урамтай байгаа. Гэвч хөдөө учраас байгаа боломжиндоо ажиллахаас биш аймгаас тэндээс авна гэх зүйлгүй байдаг юм.

Баянтүмэн сум О.Оюун-Эрдэнэ: манай сургуульд дугуйлангууд хичээллэж байгаа хүүхдүүд номоо сумын номын сандаа уншдаг. Хөтөлбөрийн хүрээнд ном ирээгүй урд нь төсөл хэрэгжсэн учраас түүндээ түшиглэн ажиллаж байна.

Халх гол сум Ж.Галтмаа: Сургуулийн номын сан төслийн хүрээнд нилээн номнууд нийлүүлэгдсэн. Хүүхэд бүр цуншихад хангалттай байрны хүүхдүүдч уншдаг. Багш нар том,жижиг номнуудыг хийж ажилладаг. Авьяас хөтөлбөрийн хүрээнд манай сургууль алслагдмал учраас хамгийн түрүүнд дэмжлэг авсан . багш нарын урамшууллыг цагт нь олгож байвал зүгээр юм.

Цаашид “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эцэг эхчүүдийн санал:

- Монгол зохиолчдын хүүхдийн зохиолыг илүү түлхүү оруулах
- Хүүхдэд ойлгомжтой үг хэллэг нь энгийн, утга санааг нь ойлгоход хөнгөн
- Бага ангийн хичээлд ном унших цаг оруулж өгөх хэрэгтэй
- Гэрээр ном өгөхөд олон хүүхдийн гар дамждаг


- Эцэг эхийг хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй хамруулах
- Ном нь зурагт, тоглоомоос чухал гэдгийг ойлгуулах
- Номын төрлийг нэмэх
- Хүүхдүүдээр бяцхан ном хийлгэх
- Том ном хийлгэж байгаа нь багш эцэг эхчүүдэд их хүндрэлтэй
- Ном худалдан авахад эдийн засгийн хувьд хэцүү
- Дунд ангийн сурагчид өөрийн гэрээс ном авчирдаг
- Ахлах дунд ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлогт таарсан ном ховор
- Гадаадын уран зохиолын ном их байна
- Ахлах ангид ангийн номын сан байдаггүйг анхаарах

Мониторингийн үйл ажиллагааны явцад авсан гэрэл зургууд

Улсын тэргүүний 1дүгээр сургуулийн багш нар, номын санч



Баянтүмэн сумын сургуулийн багш нар



8 дугаар сургуулийн багш нар



Хан-Уул цогцолбор сургуулийн багш нар



Шинэ хөгжил цогцолбор сургуулийн багш нар



Аймгийн сургуулийн нийт нийгмийн ажилтнууд



12 дугаар сургуулийн багш нар

